

ЗАВХАН АЙМГИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦ /2023 он/

д/д	Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин	2023 оны хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
			Он	Түвшин			
НЭГ. ҮНДСЭНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ							
ӨВ СОЁЛ							
1.1							
1.1.1	Соёлын биет болон биет бус өвийн судалгаа, мэдээллийн нэгдсэн сан бий болгож, өвлөн уламжлагчдыг өсвөр, үе залуучуудад сурталчлан таниулж, өвлөн уламжлуулна	Хамрагдсан хүүхэд, залуучуудын тоо	Жилд хоёр удаа	1,500	20,000	Баримтат өв эзэмшигчдийн судалгааг хийж Соёлын яаманд хүргүүлсэн. Баримтат өвийн шинэчилсэн загвараар Завхан аймгийн Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчдын анхдугаар наадмын хүрээнд 16 сумын 131 шилдэг өвлөн уламжлагчид гэрчилгээ олгож, шилдэг бүтээлүүдээр үзэсгэлэн гаргаж, ард иргэдэд сурталчлан таниулсан. Аймгийн музейн сан хөмрөгт хадгалагдаж байгаа үзмэрүүдээс хосгүй үнэт дурсгалт зүйлийн зэрэглэлд нэр дэвшүүлэх үзмэрийн судалгааг хийж жагсаалт гаргасан. Б.Цогнэмэхийн зохиолоор “Асарын өндөр” түүхэн аялгуут жүжгийг “Үндэсний бахархал Монгол өв соёл” арга хэмжээний хүрээнд тайзны бүтээл болгож, 8 удаагийн тоглолтоор 4800 үзэгчдэд хүргэсэн. Хүүхдийн ардын урлаг, соёлын “Яргуй-2023” наадмыг Монгол ардын дуу, Монгол ардын бүжиг, Монгол ардын хөгжим, ардын язгуур урлаг, Монголын уламжлалт шагайн наадгай гэсэн 5 төрлөөр зохион байгуулж, Ерөнхий боловсролын сургуулиуд, Политехник коллеж, сумдын Соёлын төвийн дэргэдэх бүжгийн дугуйлангийн 850 суралцагч оролцож, морь, бөх цоллооч 24 хүүхдийг бүртгэн баримтжуулж, үнэмлэх олгоход ОНХС -аас 3.0 сая төгрөг зарцуулсан. “Нүүдэлчин 2023” дэлхийн соёлын фестивалд оролцоход орон нутгийн хөгжлийн сангаас 20,0 сая, Соёлын яамнаас 16.8 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлж, 45 өвлөн уламжлагч амжилттай оролцсон.	70
1.1.2	Номын сангийн цахим сан хөмрөгийн эзлэх хувийг нэмэгдүүлнэ	Цахим сан хөмрөгийн эзлэх хувь	Жилд хоёр удаа	0%	4.0%	Номын сангийн цахим сан хөмрөгийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд орон нутгийн ууган хэвлэл болох Туяа сонины 1946-1990 он хүртэлх дугаарууд нийт 9933 нүүрийг Омега программд оруулж сонин хэвлэлийн 87% ийг цахимжууллаа. "Гайхмаар хурд" ХХК-аас интернэтийн хурдыг 4GB-аар өсгөн авч ашиглаж байна. Гадаад уншлагын хурдыг нэмэгдүүлэх зорилгоор Лингорс байгууллага, Xreading цахим номын сантай хамтран нийт 45 уншигч хүүхдүүдийг гадаад уншлагын марафонд оролцуулаад байна. Ж.Батсуурь, Э.Энхмаа нарын “Монгол улсын иргэн угийн бичиг хөтлөх үлгэрчилсэн загвар” номыг 25 ширхгийг худалдан авч, 23 сумын Соёлын төвийн номын санд баяжилт хийлээ. Мөн ахмад багш Ч.Янжинхүүгийн “Угийн бичиг хөтлөх арга зүй” гарын авлагыг хэвлүүлэн аймгийн хэмжээний айл өрхүүдэд хүргэхэд Соёл урлагийн газраас 200 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлж, сумдын номын сангууд уг номоос 69 ширхэг номоор баяжилт хийсэн.	90
1.1.3	Үндэсний бахархал, Монгол өв соёлоо өвлүүлэхэд чиглэсэн аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн бий болгоно	Бүтээгдэхүүн ий тоо	Жилд хоёр удаа	3	24	Цахим орчин дахь аялал жуулчлалын мэдээллийг нэгдсэн сувгаар түгээх ажлын хүрээнд аймгийн музейгээс түүх, соёлын үл хөдлөх дурсгалын тайлбар мэдээллийг БОАЖГ-т хүргүүлсэн. Их-Уул сумын Солонготын даваа, Сонгино сумын төвийн баруун талд төв зам дагуу, Цагаанхайрхан сумын Ганцын давааны угтах хаалга дээр соёлын аялал жуулчлалын мэдээлэл бүхий QR кодтой самбар хийх ажлын даалгаврыг хийж гүйцэтгэсэн. Шинжлэх ухаан археологийн хүрээлэнтэй хамтран 2023.05.13-22-ны өдрүүдэд Эрдэнэхайрхан сумын Ар Баян айраг, Эх хайрхан, Завханмандал сумын Таван лам, Аргалант, Ургамал сумын Голын Баян улаан, Бор хярын элс, Дөрвөлжин сумын Бүрчигтэй, Өвөр сайхан, Хар овоо, Яруу сумын Дулаан уул зэрэг газруудад хадны оршуулгын дурсгалыг илрүүлэх, судлах, авран хамгаалах ажлыг зохион байгуулсан бөгөөд судалгаанд 8 дурсгалт газар 8 дурсгал хамрагдсан. Ямаан усны археологийн дурсгалт газрын хүрээнд судлагдсан газруудыг аялал жуулчлалын маршрутанд оруулахаар БОАЖГ-тай хамтран ажиллаж байна.	70

1.1.4	Монгол хэл, бичгийн хэрэглээг нийтийн болон албан хэргийн түвшинд нэмэгдүүлнэ	Монгол хэл бичгийг хэрэглэж буй хувь	Жилд хоёр удаа	30%	40%	Аймгийн Засаг даргын 2023 оны "Монгол хэлний тухай хуулийн зарим арга хэмжээг эрчимжүүлэх тухай" 04 дүгээр албан даалгаврыг Сумын Засаг дарга нарт албан бичгээр хүргүүлж, албан даалгаврын хүрээнд "Монгол бичгийн орчин бүрдүүлэх сарын аян", "Хос бичигтэн байгууллага" шалгаруулах аяныг зарлаж, сурталчлах зорилгоор орон нутгийн Air 1 телевизтэй хамтран 20 минутын нэвтрүүлэг бэлтгэж, телевиз болон холбогдох байгууллагуудын албан ёсны цахим хуудсаар олон нийтэд 5 удаагийн давтамжтайгаар хүргэсэн. "Завхан-Эх хэл, бичгээ эрхэмлэе" цахим хуудас нь 3800 гаруй гишүүнтэй бөгөөд Хэлний бодлогын сумдын салбар зөвлөлийн үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчилж байна. Аймгийн хэмжээнд Төрийн байгууллагуудын 56% нь албан бичиг хэргээ хос бичгээр хөтлөх ажлыг туршиж эхлээд байна. Сумдын Засаг дарга нарт Хэлний бодлогын Үндэсний зөвлөлийн Ажлын албаны даргын 2022 оны А/38 тоот тушаалаар батлагдсан "Төрийн албан хаагчдад зориулсан монгол бичгийн сургалтын хөтөлбөр"-ийн дагуу Сумын хэлний бодлогын салбар зөвлөл, мэргэжлийн багш нартай хамтран 2023 оны 09 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн төрийн байгууллагын албан хаагчдад монгол бичгийн анхан, дунд, ахисан шатны сургалтыг тасралтгүй явуулж, хэрэгжилтийг тайлагнах үүрэг чиглэлийг албан бичгээр хүргүүлж, хэрэгжилтийг хангуулж байна. Хэлний бодлогын Үндэсний зөвлөлийн сургагч багш нартай хамтран аймгийн хэмжээнд байгууллагын архив бичиг хэргийн ажилтнуудад "Цахим бичвэр боловсруулах арга зүй" сургалтыг 2023 оны 10 дугаар сарын 16,17-ны өдрүүдэд танхимаар, байгууллагын дарга, удирдах ажилтнуудад Монгол хэлний тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл сургалтыг цахимаар зохион байгуулж, 200 гаруй удирдах ажилтан болон архив, бичиг хэргийн ажилтнууд хамрагдлаа. Төрийн байгууллагын гадна хаягжилт 60%, өрөө тасалгааны хаягжилт 50%-тай байна. Сургалт, уралдаанд 100 гаруй төрийн албан хаагч, 6536 суралцагч амжилттай оролцсон.	100
1.1.5	"Үндэсний бахархал, Монгол өв соёл" арга хэмжээг хэрэгжүүлнэ	Гүйцэтгэлийн хувь	Жилд нэг удаа	30%	80%	"Үндэсний бахархал, Монгол өв соёл" арга хэмжээг 2023 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг 3 удаа хэлэлцэж, 5 зорилтын хүрээнд 31 үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд 80,0 сая төгрөгийг зарцуулахаар аймгийн Засаг даргаар батлуулж, эрхийг СУГ-т шилжүүлсэн. Аймгийн ИТХ-ын 69 дүгээр тогтоолоор нэмж 50,0 сая төгрөг батлагдсан. 1-р зорилтын хүрээнд 5 үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд 11,0 сая төгрөгийг зарцуулж, 5379 хүүхэд, залуучуудад үйлчилгээ үзүүлсэн. 2-р зорилтын хүрээнд 12 үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд 46,9 сая төгрөгийг зарцуулж, нэвтрүүлэг, контент, аян, уралдаан тэмцээнд 9886 хүн оролцсон. 3-р зорилтын хүрээнд 4 үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд 6,8 сая төгрөгийг зарцуулж, нэвтрүүлэг, контент, сургалт, ном, гарын авлагын баяжилт хийгдсэн. 4-р зорилтын хүрээнд 4 үйл ажиллагааг хэрэгжүүлж, 3,3 сая төгрөгийг зарцуулж, сургалт, нэвтрүүлэг, уралдаан, үзэсгэлэнд 2100 хүн оролцсон. 5-р зорилтын хүрээнд 3 үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд 12,0 сая төгрөгийг зарцуулж, зөвлөгөөн, чуулган, сургалтын төлбөрийн дэмжлэгт 292 албан хаагч хамрагдсан.	70
1.1.6	Соёлын биет, биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулна	Хэрэгжилтийн хувь	Жилд хоёр удаа	20%	75%	Register4 програмд шилжиж, улсын хамгаалалтанд байх 6, Аймаг нийслэлийн хамгаалалтанд байх 21 нийт 27 дурсгал, орон нутгийн хамгаалалтанд байх 693 цэгийн 7835 дурсгалын мэдээлэл, "Соёлын биет бус өв"-ийн бүртгэлийн www.ich.mongoluv.mn программд аймгийн 552 өвлөн уламжлагчийн судалгаа, мэдээллийг шинэчлэн баяжилт хийсэн. "Нүүдэлчин Монгол" дэлхийн соёлын фестивальд Монгол улсын шилдэг өвлөн уламжлагчаар шалгарсан Д.Даваарагчаа (марзай гийнгоо) Б.Мөнхтуяа (зоосон ширээ сүлжмэл) нарын видео контент, Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг шинээр илрүүлэн, улсын бүртгэл мэдээллийн сан болох RICH программд 665 дурсгалыг бүртгэж, Хагас жилийн байдлаар Тэлмэн, Нөмрөг сумдын нутаг дэвсгэрт байрлах Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд бүртгэлгүй түүх соёлын үл хөдлөх 2 дурсгалыг шинээр бүртгэн баримтжуулж программд бүртгэсэн. Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг сурталчлан таниулах зорилгоор 2 нэвтрүүлэг, 1 видео бичлэгийг Улиастай сумд, Их-Уул сумын нутгаас эрхэмэл монгол гутал, энгийн монгол гутал хийдэг 5 өвлөн уламжлагчаас нэвтрүүлэг бэлтгэн AIR 1 сувгаар, Эсгий туургатан төслийн багт холбогдох өвлөн уламжлагчдыг холбож нэвтрүүлэг бэлтгэхэд дэмжин ажиллаж, 2 видео бичлэг, "Шагай наадгай" сэдэвт контентыг Улиастай сумын Дэвшил сургуулийн Жанцанхорол багштай 2в ангийн 34 суралцагчийг хамруулан бэлтгэж, Тосонцэнгэл суманд зохион байгуулагдсан "Сайн ноён хан аймаг баатар засгийн хошуу" түүх, соёл, байгаль сэдэвт эрдэм шинжилгээний хуралд Далай чойнхор вангийн урчууд болон Б.Гурбадам, Маньбазар нарын урласан бүтээлүүд болох 15 дэсийн 41 ширхэг үзмэр эд өлгийн зүйлээр дэглэсэн түр үзэсгэлэнгийн талаарх мэдээллийг ТВ-5 телевизэд өгч, уран хатгамалч Б.Мөнхтуяагийн Соёлын өв тээгч нэвтрүүлэг МҮОНТВ-р сар шинийн баяраар үзэгчдэд хүрсэн.	70

1.1.7	Соёл урлагийн үйлчилгээний чанар хүртээмж, нэр төрөл, хамтын ажиллагааг өргөжүүлнэ	Үйлчилгээний хүртээмж	Жилд 2 удаа	35%	60%	Сумдын соёлын төв 20 контент, ХЖТ-ын уран бүтээлчид 17 контент, Түдэвтэй сумын соёлын төв “Жогорхой” хошин дуулалт жүжиг, Паацаахайд тохиолдсон хөгтэй явдал хүүхдийн хронолт жүжиг зэргийг цахим орчноор дамжуулан түгээн дэлгэрүүлсэн байна. Соёл урлагийн газрын пэйж хуудсыг тогтмол хөтөлөн үйл ажиллагааны мэдээлэл оруулж 1,9 мянган дагагчтай болсон байна.2023 онд Соёлын төвүүд 103142,0 мянган төгрөгийн өөрийн орлогыг төвлөрүүлж, дараах зардалд зарцуулсан. Тавилга эд хогшил 3150,0, шатахуун 11500,0 урсгал засвар, ном хэвлэл 13000,0, урлаг уран бүтээл 49000,0, бичиг хэрэг 10500,0, бага үнэтэй түргэн элэгдэх зүйл 16000,0, аймгийн хэмжээнд үр дүнд суурилсан санхүүжилт 272,5 сая төгрөг авч, 2019, 2022 оны ажлаа дүгнүүлж, ажилтны нийгмийн асуудалд 15%, байгууллагын хэвийн үйл ажиллагаанд 40%, урлаг уран бүтээл хийхэд 30%, урамшуулал 15%-г зарцуулан ажиллаж байна. ОНХС-н хөрөнгөөр Сонгино сум 75 сая төгрөгийн лед дэлгэц Их-Уул сум хандиваар, үүрэн холбооны өндөр хурдны интернетийн төхөөрөмж 24 суманд холбогдсон. "Соёлын сэргэлт аян"-ыг Завхан аймагт Чойжин Ламын сүм музей, Соёл урлагийн газар хамтран зохион байгуулж, нээлтийн үйл ажиллагаанд 2488, соёл гэгээрлийн лекцэд 480, Соёлын ажилтнуудыг чадавжуулах сургалтад 198, бусад үйл ажиллагаанд /үзэсгэлэн, өдөрлөг, соёл олон нийтийн ажил/-920 , урлагийн тоглолтод 5800 гаруй хүн хамрагдсан байна. “Бүх нийтийн Соёлын боловсрол” болон “Соёлын салбарын хүүхэд хамгааллын бодлого” сэдвээр 45 номын санчдад сургалтыг зохион байгуулсан. “Бүх нийтийн Соёлын боловсрол” арга хэмжээний хүрээнд 4 сайдын хамтарсан гэрээний дагуу төлөвлөгөөг гаргаж 5 зорилтын хүрээнд 15 арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлж ажиллаж байна.	70
1.1 ДҮГЭЭР ЗОРИЛТЫН ДҮН						77.14	
НЭГДҮГЭЭР БҮЛГИЙН ДҮН						77.14	
ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ							
БОЛОВСРОЛ							
2.1							
2.1.1	Хүн бүрт чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ	Хамрагдалтын хувь	Жилд хоёр удаа	30%	95%	Төрийн өмчийн 38 цэцэрлэгийн 192 бүлэгт 4968, хувилбарт сургалтын14 бүлэгт 203, төрийн бус өмчийн 2 цэцэрлэгийн 4 бүлэгт 97 хүүхэд нийт 5268 хүүхэд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж, цэцэрлэгийн хамран сургалт 82.5%, хувилбарт сургалтын хамран сургалт 3.8%, сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 85.8% байна. Ерөнхий боловсролын 29 сургуулийн 628 бүлэгт 15611 суралцагч, Хөгжим бүжгийн коллежийн 4 бүлэгт 61 суралцагч нийт 632 бүлэгт 15672 суралцагч суралцаж, бага боловсролын хамран сургалт 95.1%, суурь боловсролын хамран сургалт 92.1% байна. Их-Уул сумын I, Тосонцэнгэл сумын III, V, VI, Тэлмэн сумын цэцэрлэгт шинээр тус бүр 1 бүлэг нэмж 130 хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулсан. 2023-2024 оны хичээлийн жилд 0-16 насны тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай 211 хүүхэд байна. Дээрх хүүхдүүдтэй ажиллаж байгаа багшид цалингийн нэмэгдэл урамшуулал өгөх, мөн ганцаарчилсан хөтөлбөрөөр ажиллах арга зүйн сургалт, зөвлөмжийг цэцэрлэг,сургуулиудад хүргүүлж ажиллаж байна. Боловсрол нөхөн олголтын санхүүжилт 2022 оны 7 дугаар сард сургууль бүр дээр нэмэлт санхүүжилтээр олгогдож сургууль завсардсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд нөхөн хамруулах боломж нь бүрдсэн. Боловсролын ерөнхий хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан аймгийн Насан туршийн суралцахуйн төвийг шинэчлэн байгуулж, бүтэц орон тоог баталж, сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох ажил хийгдэж байна.	100
2.1.2	Бүх шатны сургалтын байгууллагын сургалтын чанарыг дээшлүүлнэ	Чанарын үнэлгээ	Жилд хоёр удаа	38%	45%	Ерөнхий боловсролын Чанарын үнэлгээг 2022-2023 оны хичээлийн жилд Тосонцэнгэл сумын лаборатори 1-р сургууль, Улиастай сумын Жавхлант цогцолбор сургууль, лаборатори Чандмань-Эрдэнэ сургуулийн 6,10,12 дугаар ангийн хүүхдүүд, Политехник коллеж, Тосонцэнгэл сум дахь МСҮТ-ийн 2-3 дугаар курсын 140 суралцагч хамрагдсан. 2023-2024 оны хичээлийн жилд Мэргэжлийн боловсролын чанарын үнэлгээг автомашины засварчин, барилгын засал-чимэглэлчин, барилгын сантехникч, гагнуурчин, оёмол бүтээгдэхүүний оёдолчин, тогооч, барилгын цахилгаанчин, үсчний мэргэжлээр бичгийн шалгалт, асуулга судалгаа, хичээл ажиглалт, бүлгийн ярилцлага хэлбэрээр хийж, Тосонцэнгэл сумын МСҮТ-ийн удирдлага 2, мэргэжлийн багш 5, суралцагч 7, Политехник коллежийн удирдлага 2, мэргэжлийн багш 5, суралцагч 36 хамрагдсан. 2022-2023 оны хичээлийн жилд Монгол хэл, бичгийн шалгалтад 828 шалгуулагч бүртгүүлснээс 815 шалгуулагч шалгалтад хамрагдаж 125 шалгуулагч 400-аас бага оноо авсан байна. ЭЭШ-н хэмжээст онооны улсын дундаж 500, аймгийн дундаж 499,8 шалгагдсан. Улсын төрөлжсөн олимпиадын хоёрын даваанд 29 сургууль, мэргэжлийн боловсролын 1015 багш, суралцагч оролцож, аймгийн Засаг дарга эхний байрт шалгарсан багш, суралцагчдыг шагнаж, урамшуулахад 5.0 сая төгрөгийг зарцууллаа. Гурвын даваанд 44 багш, суралцагч Улаанбаатар хотод гурвын даваанд амжилттай оролцсон ба Улиастай сумын Ерөнхий боловсролын Дэвшил сургуулийн 11 дүгээр ангийн суралцагч С.Энхтуяа газар зүйн хичээлээр III байр, эзэлсэн. Ерөнхий боловсролын суралцагчдыг элсэлтийн ерөнхий шалгалтад амжилттай бэлтгэх зорилгоор “ЭЭШ 800” программ хангамжийг “Гранд Ай Ти” ХХК -тай хамтран хэрэгжүүлж байна. Мөн ерөнхий боловсролын сургуулийн 3.4 дүгээр ангид математикийн хичээлийн “Eduten” цахим систем, 5,6 дугаар ангийн Англи хэлний хичээлийн “Pearson” цахим хөтөлбөр, ерөнхий боловсролын сургуулийн 10,11 дүгээр ангийн 769 суралцагчид “Medlee” цахим сургуульд хамрагдаж, цахим сургалтыг хэрэгжүүлж байна.	70

2.1.3	Сургалтын орчны аюулгүй байдлыг сайжруулна	Сургалтын байгууллагын эзлэх хувь	Жилд хоёр удаа	60%	80%	Сургалтын байгууллагын нүхэн жорлонг ус, ариун цэврийн байгууламжаар солих 1,2-р ээлжийн ажлыг Улсын төсвийн 7197.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Асгат, Баянтэс, Тэс, Баянхайрхан, Ургамал, Отгон, Яруу, Нөмрөг, Сантмаргаз, Сонгино, Цагаанхайрхан, Түдэвтэй, Дөрвөлжин сумын цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрыг стандартад нийцсэн ариун цэврийн байгууламжаар сольсон. 3-р ээлжинд Улиастай, Алдархаан, Идэр, Их-Уул, Тосонцэнгэл, Тэлмэн, Цагаанчулуут, Шилүүстэй, 4-р ээлжинд Эрдэнэхайрхан, Завханмандал, Цэцэн-Уул нийт 11 сумын нийт 62 объектыг ариун цэврийн байгууламжаар солихоор 3-р ээлжийн зураг төсвийн ажил хийгдэж, магадлалаар хянагдаж байна. "Хүүхдэд ээлтэй дотуур байр" арга хэмжээний үр дүнд зөөлөн эдлэлээр хангагдсан дотуур байр 16, "Хүүхэд хөгжлийн төв"-тэй дотуур байр 4, Номын өргөө байгуулсан дотуур байр 7, Улиастай сумын Жавхлант цогцолбор сургуулийн 100 ортой дотуур байр ашиглалтад орж, Асгат, Цэцэн-Уул сумын 100 ортой дотуур байрын барилга баригдаж, Баянхайрхан, Отгон сумын дотуур байр засвар хийгдсэн. ОНХС-ийн 50,0 сая төгрөгийн хөрөнгөөр Завханмандал, 2023-2024 оны хичээлийн жилд үдийн хоолонд бага боловсролын 7450 суралцагч буюу нийт суралцагчдын 46.6% хамрагдаж байна. Улиастай сумын 3 цэцэрлэгийг ОНХС-ийн 20 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар I, II хоолны тогоо, цахилгаан жигнүүр, цахилгаан пийшин, цахилгаан махны машин, цахилгаан будаа агшаагчаар хангасан. БШУЯ-ны 6.3 сая төгрөгийн санхүүжилтээр Баянтэс сумын ЕБС-ийн гал тогоонд аяга хатаагч, ариутгагч, цахилгаан гурил зуурагч, Баянхайрхан сумын ерөнхий боловсролын сургуульд аяга таваг угаагч, хатаагч, ариутгагч автомат машин, шарах шүүгээ, цахилгаан гурил зуурагч тус тус хангасан. БШУГ, Баянтэс, Их-Уул, Тэлмэн, Тосонцэнгэл 1, 2, Баянхайрхан, Сантмаргаз сумын сургуульд "Хоол зүйч" ажиллаж байна. ОНХС-ийн 50,0 сая төгрөгийн хөрөнгөөр Завханмандал, Ургамал, Цагаанчулуут сумын сургууль, МУ-ын Консерваторийн харьяа ХБК, Политехник коллежид "Багш хөгжлийн төв"ийг байгуулсан.	50
2.1.4	Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, техник сэтгэлгээг хөгжүүлнэ	Хамрагдалтын хувь	Жилд нэг удаа	60%	85%	"Хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн нас сэтгэхүйн онцлог", "Хорт зуршил, түүнээс урьдчилан сэргийлэх арга зам", "Электрон тамхинаас татгалзая", "Хүүхдийн хөгжил төлөвшилд гэр бүлийн оролцоо", "Мэргэжил бүхэн сайхан", "Хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал, ёс зүй харилцаа хандлага" уулзалт, сургалт, аяныг эцэг эх, асран хамгаалагч, хүүхдүүдийн дунд зохион байгуулж, 9500 гаруй хүн оролцсон. Хүүхдийн ардын урлаг, соёлын "Яргуй" наадмыг Монгол ардын дуу, Монгол ардын бүжиг, Монгол ардын хөгжим, ардын язгуур урлаг, Монголын уламжлалт шагайн наадгай гэсэн 5 төрлөөр зохион байгуулж, Ерөнхий боловсролын сургуулиуд, Политехник коллеж, сумдын Соёлын төвийн дэргэдэх бүжгийн дугуйлангийн 850 суралцагч оролцлоо. Мэдээллийг Air1 телевизээр олон нийтэд хүргэсэн. Мөн Сантмаргаз сумын ерөнхий боловсролын сургуулийн суралцагч Э.Санчирмаа Хэл иргэншлийн хүрээлэнгээс зохион байгуулсан "Сайхан бичигтэн" уралдаанд улсад III байр, Улиастай сумын лаборатори Чандмань-Эрдэнэ сургуулийн суралцагч Б.Өнөрсайхан Олон улсын логик паззлын уралдаанд III байр эзэлсэн байна. Өглөөний уншлага үндэсний хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдсан улсын уралдаанд Улиастай сумын ерөнхий боловсролын III сургуулийн Ц.Наранчимэг багштай 4а анги II байр эзэлсэн.	70
2.1.5	Багшийн хөгжлийг дэмжиж, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлнэ	Хэрэгжилтийн хувь	Жилд хоёр удаа	30%	80%	"Чадварлаг багш" арга хэмжээг 2023 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг 3 удаа хэлэлцэн, "Багш бэлтгэх болон ерөнхий боловсролын сургалтын уялдаа, хамтын ажиллагааг сайжруулах" 1 дүгээр зорилтын хүрээнд 5 үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд 23,0 сая, "Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах" 2 дугаар зорилтын хүрээнд 16 үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд 257,0, "Багшийн нийгмийн баталгаа, урамшуулал, орчин нөхцөлийг дэмжих" 3 дугаар зорилтын хүрээнд 7 үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд 70,0 сая төгрөгийг зарцуулахаар аймгийн Засаг даргаар батлуулж, 300,0 сая төгрөгийн эрхийг БШУГ-т шилжүүлсэн. Тус арга хэмжээний хүрээнд шилдэг 100 багшийг шалгаруулж, зөөврийн компьютерээр шагнаж, урамшуулахад 200,0 сая төгрөгийг зарцууллаа. Мөн 28 үйл ажиллагаанд давхардсан тоогоор 3538 багш, удирдах ажилтан цахим болон танхимаар хамрагдсан байна. -Сургалт, зөвлөгөөнд 54,0 сая төгрөгийг зарцуулж, давхардсан тоогоор 2188 багш ажилтан -Олимпиад, уралдаан тэмцээнд 10,5 сая төгрөг зарцуулж, 1181 багш -Туршлага судлах үйл ажиллагаанд 17,5 сая төгрөгийг зарцуулж, 45 удирдах ажилтан, мэргэжилтэн -Урамшуулал, дэмжлэгт 218,0 сая төгрөгийг зарцуулж, 124 багш, 5 сургууль тус тус хамрагдсан.	100

2.1.6	Мэргэжлийн сургуулиудын хөгжлийг дэмжин, хамтран ажиллана	Хэрэгжилтийн хувь	Жилд нэг удаа	10%	50%	"Завхан-100" эрдэм шинжилгээний бага хурлыг Улаанбаатар хотноо АЗДТГ, Завхан судлал төвтэй хамтран зохион байгуулсан. Хуралд Завхан нутгаас гаралтай олон эрдэмтэн судлаачид, бизнес эрхлэгчид оролцож аймгийн эрчим хүч, хөдөлмөрийн зах зээл, зам харилцаа, дэд бүтэц, боловсролын хөгжлийн тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам, мөн орон нутагтаа бордоо, жимс, зөгийн аж ахуйг байгуулах, геологи, уул уурхай, аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжуудыг шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа шинжилгээнд тулгуурлан хэлэлцүүлээ. Энэхүү үйл ажиллагаанд ОНТ-өөс 15 сая төгрөг зарцуулаа. БШУЯ, Шинжлэх ухаан Технологийн сан, Монгол Улс дахь Нэгдсэн Үндэстний байгууллага, Шинжлэх ухааны академи, Завхан аймгийн Засаг даргын Тамгын газар хамтран "Шинжлэх ухаан, технологи, инновацийг орон нутагт нутагшуулья" аяныг 2023.09.28-29-нд зохион байгуулж, аяны хүрээнд: "Бүс нутгийн хөгжил, төлөвлөлт, гарц шийдэл" бодлогын хэлэлцүүлэг, инновацийн бүтээгдэхүүний үзэсгэлэн, "Миний анхны инженерчлэл" workshop арга хэмжээ, "Стартап менторшип" арга хэмжээ, "SciCon-Завхан" шинжлэх ухаан, танин мэдэхүйн арга хэмжээ, "Засагт хан аймгийн Сартуул Сэцэн засгийн хошуу: Түүх, соёл" сэдэвт эрдэм шинжилгээний хурал зохион байгуулагдаж, 1000 гаруй хүүхэд, залуучууд, бизнес эрхлэгчид, эрдэмтэн судлаачид, төрийн албан хаагчид оролцлоо. Аймгийн Засаг дарга Монгол Улсын Шинжлэх ухааны академи, ШУ-ны академийн Түүх угсаатны зүйн хүрээлэн, ХААИС-тай хамтран ажиллах гэрээ байгууллаа. Засгийн газрын 2023 оны 307 дугаар тогтоолоор МУИС-ийн Завхан сургуулийг түшиглэн ерөнхий боловсролын ахлах сургууль байгуулахаар шийдвэрлэсний дагуу сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахаар сургалтын орчныг бүрдүүлэх, суралцагчдын амьдрах орчны тохижилт үйлчилгээнд шаардлагатай санхүүжилтийг төлөвлөж байна.	50
2.1 ДҮГЭЭР ЗОРИЛТЫН ДҮН						73.33	
2.2 ЭРҮҮЛ МЭНД							
2.2.1	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлнэ	Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний багцын хэрэгжилтийн хувь	Улиралд нэг удаа	70%	80%	MNS 5081:2013, MNS 5292:2017 стандарт, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль болон бусад холбогдох хууль, журам, Эрүүл мэндийн Сайдын 2023 оны 283 тушаалаар батлагдсан "Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж, үйлчилгээний журам, жагсаалт, гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг шинэчлэн батлах тухай" тушаалыг мөрдөн ажиллаж байна. 2023 оны 10 сарын байдлаар артерийн гипертензийн эрт илрүүлэх үзлэгт 11510 иргэн хамрагдаж 24.2%, чихрийн шижин хэв шинж 2 өвчнийг эрт илрүүлэх үзлэгт 8838 иргэн хамрагдаж 30.3%, хөхний хорт хавдрын эрт илрүүлэх үзлэг 41.1%, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэх үзлэг 9.3%-тай байна. Аймгийн хэмжээнд 871 эх төрсөн нь өмнөх оноос 70 төрөлт буюу 8.7 хувиар, 874 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 62 хүүхдээр өссөн байна. Нийт төрсөн хүүхдийн 4.0 хувь нь 2500 гр-аас доош жинтэй, 5 тохиолдол буюу 0.5 хувь нь төрөлхийн хөгжлийн гажигтай төрсөн байна. Нялхсын эндэгдлийн 40.0 хувийг 0-6 хоногтой нярайн эндэгдэл, 40.0 хувийг 7-28 хоногтой нярайн эндэгдэл эзэлж байгаа ба нярайн эндэгдлийн түвшин 9.2, перинаталь эндэгдлийн түвшин 8.0 байна. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 16.0 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 12.2 промилаар буурсан байна. Эхийн эндэгдэлгүй. Амьгүй төрөлтийн 3 тохиолдол бүртгэгдэж, амьгүй төрөлтийн түвшин 3,4 буюу өмнөх оны мөн үеэс 2,2 промилаар өссөн. Халдварт бус өвчний 241358 үзлэгээс 20,6 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 64,5 хувийг амбулатори, 6,5 хувийг диспансерын идэвхтэй хяналтын үзлэг, 3,7 хувийг гэрийн дуудлагын үзлэг тус тус эзэлж байна. Нийт нас баралтын 282 тохиолдол бүртгэгдсэний 20,2 хувийг эмнэлгийн нас баралт, эмнэлэгт нас барсан тохиолдлын 29,8 хувийг хоног болоогүй нас баралт эзэлж байна. Нас баралтын нас баралтын түвшнээр нь ангилж үзвэл хорт хавдар 11,0, гадны шалтгаант нас баралт 3,9, халдварт өвчин 0,1 байна. Урьд онтой харьцуулахад гадны шалтгаант нас баралт 5 тохиолдлоор буурч, хорт хавдрын нас баралт 1	100
2.2.2	Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна	Хамрагдалтын хувь	Жилд хоёр удаа	70%	90%	Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж буй 7 арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. - "Эрүүл идэвхтэй амьдрал -2023" төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 28 үйл ажиллагаа, "Хавдрын өсрөг арга хэмжээ 3 зорилт 16 ажил, Харшлаас сэргийлэх арга хэмжээ 3 зорилт, 15 үйл ажиллагаа, Элэг бүтэн Монгол арга хэмжээ 4 зорилт, 21 ажил, Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх" арга хэмжээний 8 зорилт 52, НҮЭМ арга хэмжээ 5 зорилт 12 үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хэрэгжилт 70 хувьтай. Артерийн гипертензийн үзлэгт 9684 иргэн хамрагдаж 20,4%, чихрийн шижин хэв шинж 2 өвчнийг эрт илрүүлэх үзлэгт 8570 иргэн хамрагдаж 35,6%, хөхний хорт хавдрын эрт илрүүлэх үзлэгт 899 иргэн буюу хамралт 3,9%, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэх үзлэгт 360 иргэн буюу 7,2%-тай байна. Гэмтэл хордлого гадны шалтгаант осол гэмтлийн 997 шинэ тохиолдол бүртгэгдэж, үүнээс 34 тохиолдол нас барсан байна. Осол гэмтлийн шалтгаант өвчлөл, нас баралт өмнөх оны мөн үеэс 37,9%-иар, нас баралт 14,7%-иар тус тус өссөн байна. Нийгмийн эрүүл мэндийн 20 тэмдэглэлт өдөр 5 нэгдсэн арга хэмжээний хүрээнд AIR 1 телевизээр 19 удаагийн ярилцлага, мэдээ дамжуулснаас 4 мэдээллийг МҮОНРТ-ээр дамжуулсан. Нийт 31 төрлийн зөвлөмж, дүрс бичлэг, 12 зурагт хуудас зөвлөмж, 5 удаагийн үгэн зарыг дамжуулж нийт 48052 удаагийн цацалт хийгдсэн. Завхан сониноор 2 удаагийн зөвлөмж, ярилцлага, мэдээ нийтлүүлсэн. Сурталчилгааны 23 материалуудыг Онлайн дизайны "Canva" платформ ашиглах боловсруулсан. Нийт цахим хуудсаар 598 төрлийн зурагт хуудас түгээж 342838 хандалт авсан байна.	70

2.2.3	Оношлогоо, эмчилгээний дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ	Нэвтрүүлсэн технологи	Жилд нэг удаа	2	5	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн "Эрүүл мэндийг дэмжих төв" нь эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог хийж байна. Бриллиант эмнэлэгтэй хамтран ходоодны эрт үеийн хавдар хуулах хагалгаа - 2, улаан хоолойн өргөссөн судас боох ажилбарыг орон нутагт хийсэн. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмч нар улаан хоолой, бүдүүн гэдэсний ургацаг авах 46 ажилбарыг хийсэн байна. Зүрх судасны кабинет нь зүрхний ачаалалтай сорилыг хийж эхлээд 25 хүнд тусламж үйлчилгээ үзүүлснээс 7 хүнийг ангиографийн шинжилгээнд явуулж стент тавиулсан."Гурван гал" эмнэлэгтэй хамтран чихний хэнгэрэг нөхөх, хамрын муруй засах, хамрын таславчын муруй засах, хамрын хөндийн ур авах, самалдаг түлэх, самалдаг тайрах хагалгааг 176 хүнд хийсэн. Гэмтлийн гаралтай тархины бүх төрлийн хагалгааг хийж, 11 хүнд тархины хагалгаа амжилттай хийгдсэн байна. Дунд чөмгөний хугарлыг CRM аппаратын тусламжтайгаар түгжих хагалгааг нэвтрүүлэн 4 тохиолдолд тусламж, үйлчилгээг амжилттай хийсэн. Мэргэшсэн эмчтэй Урологийн кабинет байгуулагдан бөөр шээсний доод замын дурангийн хагалгаа ажилбарыг хийж, түрүү булчирхайн дурангийн хагалгаа-25, бөөрний усжилтын улмаас шээлгүүрт стент гуурс тавиулах-3, давсганы чулуу-1, шээдэг сүвний нарийсал-3, давсганы хавдар-1 хийгдсэн байна.	70
2.2.4	Эрүүл мэндийн салбарын хүний нөөц, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ	Хамрагдалтын хувь	Хагас жилд нэг удаа	70%	100%	Эрүүл мэндийн салбарын хэмжээнд 1145 албан хаагч ажиллаж байгаагаас их эмч 186, сувилагч тусгай мэргэжилтэн 546 байна. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын эмч нарын 54 хувь нь, лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын эмч нарын 95 хувь нь үндсэн болон төрөлжсөн нарийн мэргэшил эзэмшсэн, ахлах зэрэгтэй их эмч 34, сувилагч тусгай мэргэжилтэн 114, тэргүүлэх зэрэгтэй их эмч 13, сувилагч тусгай мэргэжилтэн 56 байна. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын хөтөлбөрийн хүрээнд аймгийн Засаг дарга 2023 онд 15 эмч, сувилагч, эмнэлгийн ажилтан нарыг Засаг даргын Жуух бичиг, мөнгөн шагналаар шагнасан. 2022 онд Чадварлаг эмч арга хэмжээний хүрээнд "Чадварлаг баг, хамт олон"-ыг шалгаруулан 25.0 сая төгрөгөөр урамшуулсан. 2023 онд эрдэм шинжилгээний бага хуралд оролцсон, илтгэл тавьж байр эзэлсэн эмч сувилагч нарыг чадварлаг эмч арга хэмжээний зардлаас 10 сая төгрөгөөр урамшуулсан. 2023 оны "Чадварлаг баг, хамт олон"-ыг шалгаруулж урамшуулахаар 25,0 сая төгрөгийг батлуулан, удирдамж, шалгуурыг эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн. Эрүүл мэндийн байгууллагууд тохиолдолд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжин Эрүүл мэндийн даатгалын сангаас бүрэн санхүүжилтийг авч байна. Үүнтэй холбогдуулан санхүүжилт тодорхой хэмжээнд нэмэгдэж байгаагаар уялдуулан аймгийн Нэгдсэн эмнэлэг, Тосонцэнгэл сумын Нэгдсэн эмнэлэг нь албан хаагчдын цалинг 15-30 хувиар нэмэгдүүлсэн байна.	70
2.2 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН						77.5	
2.3 БИЕИЙН ТАМИР, СПОРТ							
2.3.1	Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлнэ	Үйлчилгээний хүртээмж	Жилд нэг удаа	22%	40%	Биеийн тамир, спортын газрын бүтцийг аймгийн Засаг даргын захирамжаар баталж, нийтийн биеийн тамирын хэлтсийг байгуулж ахлах мэргэжилтэн, 4 мэргэжилтний орон тоог батласан. Хөдөлгөөн-Эрүүл мэнд арга хэмжээний зорилтын хүрээнд: "Амка dance" бүжгийн клуб, "Цогт фитнес" бялдаржуулах төв, "Амьдрал амьдрал" ТББ, "Ахмадын хороо"-той хамтран ажиллаж байна. Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийг бууруулах, "Энэ жилдээ - эрүүл жиндээ" аяны хүрээнд эрүүл зохистой болон таргалалтын үеийн 4-5 төрлийн хоол, зутан, зуушны үзэсгэлэнг гаргаж, олон нийтийн сүлжээгээр түгээн ажиллалаа. ТҮМЭН дасгалыг ажлын байран дээрээ хийж хэвшсэн байгууллага, иргэд 30 хувьтай байна. Сум бүрд явган аялал алхалт, идэвхтэй хөдөлгөөнийг хийж хэвшээд байгаа бөгөөд аймгийн хүн амын 40 хувь нь идэвхтэй хөдөлгөөнийг хийж хэвшээд байна Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй "Нийтийн биеийн тамир, спортод цаг гаргая" 2 сарын аяны хүрээнд нийтийг хамарсан биеийн тамир, спортын уралдаан тэмцээнүүд, дугуйн аялал, бүх нийтийн алхалт, уулын аялал, чийрэгжүүлэлт, фитнес, клубийн үйл ажиллагаа, өглөөний дасгал, гүйлт, шугаман бүжиг, биелгээ гэсэн төрлөөр 50 гаруй үйл ажиллагааг зохион байгуулж, давхардсан тоогоор 24 сумын 60139 хүн хамрагдсан. Аяны үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон байгууллага, иргэд аж ахуй нэгж, сумдыг урамшуулж 50.0 сая төгрөгийг зарцуулсан байна. Цэцэрлэг, сургуулийн нийт суралцагчдын 85 хувь нь өдөр тутам дасгал хөдөлгөөн, ЕБ-ын сургууль их завсарлагааны дасгалыг хийж байна. Төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа, оролцоо нэмэгдсэн. Албан байгууллага, аж ахуй нэгж, спортын холбоотой хамтран Завхан аймагт улс, бүсийн чанартай 5 тэмцээн уралдааныг зохион байгуулсан. (Амар амьдрал ТББ, Амка dance бүжгийн клуб нь спорт бүжгийн 170 сургагч багш бэлтгэсэн. 500-1000 хүний бүрэлдэхүүнтэй бий биелгээ, шугаман бүжиг, нийтийн спорт бүжгийн тоглолт хийсэн.) ЕБ-ын 13 сургууль бялдаржуулах кабинетыг байгуулж, тоног төхөөрөмжтэй болсон байна.	90

2.3.2	Үндэсний болон мэргэжлийн спортыг хөгжүүлнэ	Тамирчдын тоо	Жилд нэг удаа	1830	4500	Улсын болон олон улсын хэмжээний тэмцээн уралдааныг зохион байгуулах зорилтын хүрээнд: Монголын хүүхдийн спортын зуны VII наадмын баруун бүсийн сагсан бөмбөгийн тэмцээнийг аймагт зохион байгуулж, үйл ажиллагаанд нь аймгийн Засаг даргын нөөц сангаас 3.5 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн. Тэмцээнд Увс, Ховд, Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан аймгийн 120 тамирчин оролцож, аймгийн эрэгтэй, эмэгтэй баг тамирчид 1, 3 байранд шалгарч Баянхонгор аймагт зохион байгуулагдах хүүхдийн спортын шигшээ тэмцээнд оролцох эрх авсан. Завхан аймгийн Алдархаан сумын уугуул, Монгол Улсын гавьяат дасгалжуулагч Пүрэвийн Жигжидсүрэнгийн нэрэмжит "Ахмад шатарчид"-ын улсын аварга шалгаруулах 18 дахь удаагийн тэмцээнийг 2023 оны 06 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд "Ажлын хэсэг" байгуулж тэмцээнийг зохион байгуулсан. Монголын "Хөл бөмбөгийн холбоо"-той хамтран 21 аймгийн түвшинд зохион байгуулж буй Грассрүүдтс сургалт, аймгийн Засаг даргын нэрэмжит өсвөрийн U14, U16 насны аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулсан. Завхан аймгийн Сантмаргаз сумын харьяат самбо бөхийн дэлхийн хошой мөнгө, жүдо бөхийн олон улсын тэмцээний алт, мөнгө, хүрэл медальт олон улсын хэмжээний мастер Янжмаагийн Доржийн нэрэмжит "Завхан цом"-2023 өсвөр үеийн жүдо бөхийн тэмцээнийг үндэсний хэмжээнд зохион байгуулсан. Сар шинийн харваа -2023" үйл ажиллагаанд 2.8 сая, Даян мэргэн арга хэмжээнд 15.0 сая, аймгийн үндэсний харвааны цол хүртсэн харваачдад 962 мянга, аймгийн Хөл бөмбөгийн холбоонд 4.2 сая, Самбо бөхийн азийн аварга шалгаруулах тэмцээнд оролцогч Бямбадоржид 1.5 сая, аймгийн Марафон гүйлтийн тэмцээнийг зохион байгуулахад 1.0 сая, Хүүхдийн спортын VII наадамд оролцогч тамирчдад дэмжлэг 10.0 сая, баруун бүсийн сагсан бөмбөгийн тэмцээнд 3.5 сая, Я.Доржийн нэрэмжит "Завхан цом"-2023 өсвөр үеийн жүдо бөхийн тэмцээнд 8.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.	70
2.3 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН						80	
2.4.	ГЭР БҮЛ						
2.4.1	Гэр бүлд чиглэсэн арга хэмжээний чанар хүртээмжийг сайжруулна	Хамрагдсан тоо	Жилд нэг удаа	4,993	6,000	Аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан "Тогтвортой амьдрал амгалан гэр бүл" арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сургалт, нөлөөллийн ажлыг 8 удаа зохион байгуулж 260 гэр бүлийг хамруулсан. Мөн бүх сум, төрийн болон төрийн бус байгууллагууд "Тогтвортой амьдрал амгалан гэр бүл" арга хэмжээний хүрээнд гэр бүлийн мэдлэг хандлага чадвар төлөвшүүлэх, Гэр бүлийн тухай хууль тогтоомжийг сурталчлах, гэр бүлийн үнэ цэнийг олон нийтэд хүргэх, түгээх ажлыг зохион байгуулан 5300 орчим гэр бүлийг хамруулсан байна. Мөн шинээр гэр бүл болж буй залуучуудад "Гэрлэхийн өмнөх боловсрол олгох сургалт, үйлчилгээг хүргэх" гэрлэлтийн батлах гардуулах ёслолын өргөөг орон нутгийн төсвийн санхүүжүүлт (25 сая төгрөг)-ээр засварлан тохижуулж байна.	50
2.4.2	Хүүхэд хөгжил, хамгааллын үйл ажиллагааг өргөжүүлнэ	Нийт төсвийн зарцуулсан хөрөнгийн хувь	Жилд нэг удаа	0%	10%	Хүүхдийн хөгжил, хамгааллын үйл ажиллагааг өргөжүүлэх ажлын хүрээнд хүүхдийг нийгмийн амьдралд оролцох, эвлэлдэн нэгдэх, хүүхдийн эрхийг хангах аливаа асуудлаар шийдвэр гаргахад оролцох, "Тэгш оролцоо-2023" баруун бүсийн хүүхдийн чуулганыг Завхан аймгийн хүүхдийн "Даян-Очир" зусланд 2023 оны 06 дугаар сард Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан аймгийн 253 хүүхэд, чиглүүлэгч багшийг оролцуулан зохион байгуулсан. Чуулганд оролцож буй 4 аймгийн хүүхдүүд Өвөл, Зун, Намар, Хавар гэсэн дөрвөн бүлэгт хуваагдан "Монгол бахархал" өртөөчилсэн үйл ажиллагааны хөтөлбөр, "Хамтдаа бүтээцгээе" амьдрах ухааны өртөөчилсэн хөтөлбөр, "Монголын хүүхдийн зөвлөл"-ийн өдөрлөг, "Урлаг-Спорт"-ын чөлөөт сонголтын хөтөлбөрийн хүрээнд 5 өдрийн турш зуслангийн хөгжлийн хөтөлбөрт хамрагдаж, хүүхдүүд аймгуудын бахархал болсон зүйлийг таньж мэдэх, багаар ажиллах, өөрийгөө илэрхийлэх, авъяасаа хөгжүүлэх бусдыг хүндэтгэх, хайрлахад суралцан, шинэ найз нөхөдтэй болж, цагийг бүтээлч, хөгжилтэй өнгөрүүлсэн. Оролцогч хүүхдүүд "Сургууль, сум орон нутгийн хэмжээнд тулгамдаж буй хүүхдийн асуудал"-ыг хэлэлцэж орон нутгийн удирдлагуудад "Бидний дуу хоолой" илгээлтээ хүргүүллээ. Уг илгээлтийг Завхан аймгийн 24 сумын Засаг дарга нарт хүргүүлэн орон нутгийн бодлого боловсруулахад хүүхдийн дуу хоолойг сонсох, хүүхдийн саналыг харгалзан үзэж шийдвэрлэн ажиллахыг үүрэг чиглэл болгосон. Хүүхдийн хөгжил хамгааллын чиглэлээр сургалт нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулан бүх сум, сургууль, цэцэрлэг, хүүхдийн байгууллагад хүрч ажиллан хүүхдийн дуу хоолойг сонсож, хамтран ажиллаж байна.	70

2.4.3	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах үйлчилгээний чанарыг сайжруулна	Хүний тоо	Жилд нэг удаа	21	96	2023 онд Жендэрт суурилсан хүчирхийлэл ба Гэр бүлд суурилсан хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх Нэг цэгийн үйлчилгээний төв нь Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогч 51 хүн (насанд хүрсэн 26, хүүхэд 25)-ийг 1-10 хоногийн хугацаатайгаар 184 хоног хамгаалах байранд байрлуулан, аюулгүй байдлыг хангаж, хохирогчдод шаардлагатай багц үйлчилгээнүүдийг төлөвлөн үзүүлсэн. Нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр хохирогчдод сэтгэлзүйн зөвлөгөө өгөх орчинг бүрдүүлэх, амьдрах ухааны сургалт олгох зорилгоор 4 улирлын хүлэмж байгуулан өгөрсий, помидор тариалж, хүлэмжний дотор хэсэгт сэтгэл зүйн булан байгуулан ажилласан. Утсаар 12 иргэнд сэтгэл зүйн зөвлөгөө өгч ажилласан байна. Нэг цэгийн үйлчилгээний төвд аймгийн Засаг даргын захирамжаар 2023 онд 20,0 сая төгрөгний дэмжлэгийг аймгийн ОНТ-өөс олгосон. Нэг цэгийн үйлчилгээний төвийн эрх зүйчийг "И тусламжийн арга зүй", "Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, насанд хүрэгчидтэй ажиллах кейс үйлчилгээ" зэрэг 10 удаагийн сургалт, хэлэлцүүлэгт хамруулж чадавхжуулсан байна. Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэй "Гүүд нэйборс" олон улсын төрийн бус байгууллагаас зохион байгуулсан "Сэтгэл зүйн зөвлөгөөний цогц сургалт"-нд Нэг цэгийн үйлчилгээний төвийг хамруулан 2,1 сая төгрөгний сэтгэл зүйн үйлчилгээний цогц хөтөлбөрийн багц хэрэглэгдэхүүнээр хангасан.	30
2.4.4	Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний чанарыг сайжруулна	Үйлчилгээний чанарын хувь	Жилд нэг удаа	25%	99%	Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч 592 өрх, 621 хүүхдэд эргэн хяналт хийж эрсдэлийн программа шинэчлэн ажиллаж байна. Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдөд үйлчилгээ үзүүлэх Нэг цэгийн үйлчилгээний төвөөр 16 хүүхэд хүлээн авч үйлчилсэн ба 18 хүүхдэд хувцас олгож, 30 хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр ажиллан, 9 хүүхдэд шинжээчийн дүгнэлт гаргаж хамтран ажилласан. 2023 оны 11 сарын байдлаар Хүүхдийн тусламжийн утас 108-д ирсэн 55 дуудлагын 33 хааж ажиллалаа.	70
2.4.5	Хөдөлмөр эрхлэлтэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулах түвшинг нэмэгдүүлнэ	Хүний тоо	Жилд нэг удаа	109	172	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 21 иргэнийг хамруулан 168.0 сая төгрөгийг зарцуулаад байна. Хөтөлбөрийн хүрээнд 21 шинэ ажлын байр бий болгож, 41 иргэнийг аж ахуй эрхлэлтийн сургалтад хамруулсан. Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулвал зохих 164 байгууллага байгаа бөгөөд хөдөлмөр эрхэлж буй 174 хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй нөхөн төлбөрт 15,0 сая төгрөгийг ХЭДСанд хуримтуулсан байна.	100
2.4.6	Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх ахмадуудыг дэмжинэ	Зөвлөхийн тоо	Жилд нэг удаа	202	300	Хөдөлмөр Эрхлэлтийн Үндэсний Зөвлөлийн 2023 оны 01 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг зохион байгуулах, ахмад настанд санхүүгийн дэмжлэг олгох, хүүхэд хамгаалагч үйлчилгээг зохион байгуулах гэсэн 3 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 30 ахмад мэргэжилтнээс зөвлөх үйлчилгээг авч 32,4 сая төгрөгний урамшуулал олгохоос 2023 оны эхний 10 сарын байдлаар 5 мэргэжилтнээс 3 байгууллагад 1200 цагийн зөвлөх үйлчилгээг үзүүлэн 5,4 сая төгрөгийг зарцуулсан. Үр дүнд нь 5 түр ажлын байр бий болсон. Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын хүрээнд 38 төслийг хүлээн авч, 21 ахмадын төсөл шалгарч, 24 сарын хугацаанд эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр гэрээ байгуулан ХЭДС-аас 105,0 сая төгрөгний дэмжлэг олгогдон 21 шинэ ажлын байр бий болсон. Хүүхэд хамгаалагч төслийг аймгийн Цагдаагийн газартай хамтран хэрэгжүүлж, Тосонцэнгэл суманд 2 ахмад настанг ажиллуулж байна. Хүүхэд хамгаалагч ахмад настан үйлчилгээний гэрээт хугацаанд 1,680,000 төгрөгний урамшууллыг олгохоор төлөвлөж 2-4 түр ажлын байр бий болгон ажиллаж байна.	50
2.4.7	Залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ	Залуучуудын тоо	Жилд нэг удаа	109	172	Аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн төв болон Их-Уул суманд залуучуудын хөгжлийн төв ажиллаж байна. Залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд Их-Уул суманд залуучуудын хөгжлийн төвийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 160 сая төгрөгийн санхүүжилтээр байгуулж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын 65 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн тусалцаа үзүүлж ажиллах хүчнийг жендэрийн болон залуучуудын хөгжлийн чиглэлээр ажиллах арга зүйн сургалтанд хамруулж чадавхижуулсан. Аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын Залуучуудын хөгжлийн төв, Их-Уул сум дахь залуучуудын хөгжлийн төвөөс харьяалах нутаг дэвсгэрийн залуучуудад сургалт нөлөөллийн болон, олон нийтийг хамарсан ажлуудыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна.	50

2.4.8	Гэр бүлийн гишүүдийн жендэрийн эрх тэгш байдлын талаарх ойлголт хандлагыг нэмэгдүүлнэ	Хамрагдсан иргэдийн тоо	Жилд нэг удаа	202	300	Жендэрийн салбар хорооны 2023 оны төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Гэр бүлийн гишүүдийн жендэрийн эрх тэгш байдлын талаарх ойлголт хандлагыг нэмэгдүүлэх нөлөөллийн ажлын хүрээнд аймгийн хэмжээнд төрийн болон төрийн бус байгууллагуудаас сургалт сурталчилгаа, оролцоо, нөлөөллийн 68 төрлийн ажил хийгдэж, 5800 орчим гэр бүлийг хамруулсан байна. Жендэрийн үндэсний хорооноос зохион байгуулсан аянд идэвхтэй оролдож хамтран ажиллалаа. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн "Эрүүл мэндийг дэмжих төв"-д Андрологийн 1 кабинетыг байгуулан Орон нутгийн хөгжлийн сангаас 19,500,000 төгрөгөөр 12 нэр төрлийн багаж, тоног төхөөрөмжөөр ханган урологийн эмч эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэн үйл ажиллагаа нь тогтворжиж байна. Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/449 дүгээр тушаалаар батлагдсан "Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх кабинетын үлгэрчилсэн загвар, ажиллах журам"-ыг хэрэгжүүлэн эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт нийт 493, насны байдлаар 0-19 насны 100, 20-39 насны 67, 40-49 насны 47, 50-64 насны 126, 65-с дээш насны 153 эрэгтэйд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. Үүнээс: дурангийн хагалгаа 18, нээлттэй хагалгаа 20 хийсэн байна.	100
2.4.9	Халамж зайлшгүй хүрэх зорилтот бүлгүүдэд халамжийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэнэ	Үйлчилгээ авсан иргэдийн тоо	Жилд нэг удаа	16176	15124	Нийгмийн халамж зайлшгүй шаардлагатай зорилтот бүлгийн 14190 иргэнд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж хөнгөлөлт тусламжийг үзүүлсэн байна.	70
2.4 ЗОРИЛТЫН ДҮН							65.56
ХОЁРДУГААР БҮЛГИЙН ДҮН							74.10
ГУРАВ. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА							
3.1. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ							
3.1.1	Ажил эрхэлдэггүй, мэргэжлийн сургалтад хамрагдаагүй залуучуудын нийт хүн амд эзлэх хувийг бууруулна	Залуучуудын эзлэх хувь	Жилд нэг удаа	25.7%	15%	Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн анхан шатны мэдлэг олгох, ажлын байран дахь харилцааны ур чадвар, сэтгэл зүйн сургалтад 4 сумын 75 залуучууд хамруулсан. Сургалтын үр дүнд анкет бэлтгэх, ажлын ярилцлагад бэлтгэх, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллгатай танилцах түүнд тохируулан асуулгад бэлтгэх, ажлын байр бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх мэдээллийг олж мэдэн түүнтэй хэрхэн танилцах зэрэг суурь ур чадварыг олгож иргэдийг хөдөлмөрийн зах зээлд нэвтрэх, ажил хөдөлмөр эрхлэх орлого ашиг олоход нь дэмжлэг үзүүлж байна. Мөн "Старт-Ап" залуучуудад гарааны бизнесийн дэмжлэг үзүүлэх сургалт, зөвлөгөө мэдээллийг өгч шалгарсан багт санхүүгийн дэмжлэг олгосон.	50
3.1.2	Аймгийн ажиллах хүчний оролцооны түвшинг нэмэгдүүлнэ	Ажиллах хүчний оролцооны түвшин	Улирал бүр	80%	88%	2023 онд 1635 шинэ ажлын байр бий болгохоор төлөвлөснөөс байнгын ажлын байранд 332, улирлын ажлын байранд 60, түр ажлын байранд 657 нийт 1049 иргэн ажилд орсон бөгөөд үүнээс эмэгтэй 612 иргэн байна. Эхний 10 сарын байдлаар 1199 иргэн шинээр бүртгүүлж тайлант сарын эцэст 352 ажил хайгч иргэн идэвхтэй байгаагаас 202 нь эмэгтэй ажил хайгч байна. Ажил хайгч иргэдийн 274 буюу 77.8 хувь нь боловсролтой, мөн 139 буюу 39.4 хувийг 15-34 насныхан эзэлж байна. Ажиллах хүчний оролцооны түвшин 3-р улирлын байдлаар 77.1 хувь байна.	70
3.1.3	Эдийн засгийн идэвхтэй хүн амын нийгмийн даатгал төлөлтийг нэмэгдүүлнэ	Шимтгэл төлсөн иргэдийн хувь	Улирал бүр	23%	60%	Нийт аж ахуйн нэгж байгууллагын 81,2 хувь буюу 706 ажил олгогчийг нийгмийн даатгалд хамрууллаа. Нийгмийн даатгалд 23185 хүн хамрагдсаны 4065 иргэн буюу 17.5% нь сайн дурын даатгуулагч байна. Эдийн засгийн идэвхтэй хүн амын 40,1 хувийг нийгмийн даатгалд хамруулсан байна.	100
3.1.4	Боловсон хүчнийг ажлын байрны захиалгад нийцүүлэн сургаж ажилгүйдлийн түвшинг бууруулна	Ажилгүйдлийн түвшин	Улирал бүр	6.2%	5.9%	Ажлын байр бий болгох нөхцөл боломж болон иргэдийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан богино хугацаанд ур чадвар олгох сургалтыг зохион байгуулан ажиллаж байна. 2023 онд мэргэжлийн сургалтын байгууллагатай хамтран Оёдол эсгүүр, Тогооч, Сантехникийн чиглэлээр 45 иргэнийг танхимын сургалтад хамруулан 3 чиглэлээр 2-р түвшний чадамж олгосон. Сургалтад хамрагдсан иргэдийн 66.6 хувь буюу 30 иргэнийг ажилд зуучилсан байна. Мөн ажил олгогчоос 219 ажлын байрны захиалга ирж, 48.8 хувьд нь буюу 107 иргэнийг ажлын байранд зуучилсан байна.	100
3.1.5	Хөдөлмөрийн насны хүн амд эзлэх хөдөлмөр эрхлэлтийн хувийг нэмэгдүүлнэ	Хөдөлмөрийн насны хүн амын ажил эрхлэлтийн түвшин	Жилд нэг удаа	74.4%	93.0%	2023 онд 1635 шинэ ажлын байр бий болгохоор төлөвлөснөөс байнгын ажлын байранд 332, улирлын ажлын байранд 60, түр ажлын байранд 657 нийт 1049 иргэн ажилд орсон бөгөөд үүнээс эмэгтэй 612 иргэн байна. Эхний 10 сарын байдлаар 1199 иргэн шинээр бүртгүүлж тайлант сарын эцэст 352 ажил хайгч иргэн идэвхтэй байгаагаас 202 нь эмэгтэй ажил хайгч байна. Ажил хайгч иргэдийн 274 буюу 77.8 хувь нь боловсролтой, мөн 139 буюу 39.4 хувийг 15-34 насныхан эзэлж байна.	70
3.1.6	Албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг цахимжуулж ашиглалтыг нэмэгдүүлнэ	Албан бус хөдөлмөр эрхлэгчдийг бүртгэлжүүлж, ажилд зуучилсан тоо	Жилд нэг удаа	350	1,500	Аймгийн хэмжээнд ХАА-н салбарт 16,087 иргэн, ХАА-н бус салбарт 3690 иргэн албан бус хөдөлмөр эрхэлж байна.	0

3.1.7	Шинээр бий болгосон байнгын ажлын байрны тоо	Ажлын байрны тоо	Улирал бүр	1250	4500	2023 онд 1635 шинэ ажлын байр бий болгохоор төлөвлөснөөс байнгын ажлын байранд 332, улирлын ажлын байранд 60, түр ажлын байранд 657 нийт 1049 иргэн ажилд орсон бөгөөд үүнээс эмэгтэй 612 иргэн байна. Эхний 10 сарын байдлаар 1199 иргэн шинээр бүртгүүлж тайлант сарын эцэст 352 ажил хайгч иргэн идэвхтэй байгаагаас 202 нь эмэгтэй ажил хайгч байна. Ажил хайгч иргэдийн 274 буюу 77.8 хувь нь боловсролтой, мөн 139 буюу 39.4 хувийг 15-34 насныхан эзэлж байна.	30
3.1.8	Ядуурлын үндэсний түвшнээс доогуур амьжиргаатай хүн амын эзлэх хувийг багасгана	Ядуурлын түвшингээс доогуур орлоготой хүн амын хувь	Жилд нэг удаа	25.7%	18%	2023 онд 1635 шинэ ажлын байр бий болгохоор төлөвлөснөөс байнгын ажлын байранд 332, улирлын ажлын байранд 60, түр ажлын байранд 657 нийт 1049 иргэн ажилд орсон бөгөөд үүнээс эмэгтэй 612 иргэн байна. Эхний 11 сарын байдлаар 1199 иргэн шинээр бүртгүүлж тайлант сарын эцэст 352 ажил хайгч иргэн идэвхтэй байгаагаас 202 нь эмэгтэй ажил хайгч байна. Ажил хайгч иргэдийн 274 буюу 77.8 хувь нь боловсролтой, мөн 139 буюу 39.4 хувийг 15-34 насныхан эзэлж байна.	30
3.1 ДҮГЭЭР ЗОРИЛТЫН ДҮН							56.25
3.2. БИЗНЕСИЙН САНХҮҮЖИЛТ							
3.2.1	Өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлж дэмжлэг үзүүлнэ	Санхүүгийн сургалтад хамрагдаж ЖДҮ, ХЭДС-ийн зээл авсан өрхийн хувь	Жилд нэг удаа	10%	100%	Орон нутагт сумдын ХААТасгийн ЖДҮ хариуцсан мэргэжилтнээр дамжуулан иргэдэд Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээл болон Хоршоо хөгжүүлэх сангийн хөнгөлөлттэй зээлийн төсөлд тавигдах шаардлага, бүрдүүлэх материал болон холбогдох мэдээллийг өгсөн. 2022 онд ХХСангаас 104 аж ахуйн нэгж, хоршоо, иргэнд зээл олгосон бол 2023 оны 11 сарын байдлаар 127 аж ахуйн нэгж, хоршоо, иргэнд зээл олгосон нь өмнөх оноос 22.1 хувиар өссөн байна.	30
3.2.2	Бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийн бэлтгэн нийлүүлэлт, борлуулалтын тогтолцоог кластерын зарчмаар хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ	Нийлүүлэлтийн гинжин харилцаа тогтоосон бизнес, үйлдвэрийн тоо	Жилд 1 удаа	0	5	Орон нутгийн брэнд бүтээгдэхүүн борлуулдаг Завханд үйлдвэрлэв онлайн дэлгүүр Хүннү зоогийн газрын танхимд 13 аж ахуйн нэгж үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүнийг борлуулж байна. "Мөнхөд Мандаг" ХХК Номин, Оргил, Хайпи сүлжээ дэлгүүрт 11 төрлийн бүтээгдэхүүн, "Завхан баялаг" ХК Баялаг Төв супермаркет, Номин сүлжээ дэлгүүрүүд, Скай их дэлгүүр, Оргил сүлжээ дэлгүүрүүд, Баясах сүлжээ дэлгүүрүүд, Home plaza сүлжээ дэлгүүрүүд, Дархан хотын Ижий зах, Эрдэнэт хотын "Бат-Ач" ХХК-ий бөөний дэлгүүр, Улиастай сумын "Завхан Баялаг" ХК-ийн нэрийн барааны дэлгүүр зэрэг худалдааны төвүүдээр дамжуулан 20 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг худалдан борлуулж байна.	70
3.2.3	Сумдын гарааны бизнес эхлүүлж буй иргэдийн ЖДҮХС, СХС, ХЭДС-ийн зээлийн хамрагдалтыг нэмэгдүүлнэ	Анх удаа тухайн сангаас зээл авсан зээлдэгч	Улирал бүр	10%	30%	АНУ-ын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр Хөгжлийн шийдэл ТББ байгууллагын хэрэгжүүлж буй BEST хөтөлбөрөөс Ногоон анд ХХК Улаан хальст саримс тариалалтын хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор 10.0 сая төгрөг, Жинст хайрханы эрдэнэ арвижих ХХК улаан хальст саримс боловсруулж бүтээгдэхүүн болгоход зориулж 8.2 сая төгрөгийн буцалтгүй тэтгэлэг олгосон. Хөгжлийн шийдэл ТББ-ын Best хөтөлбөрөөс гарааны бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор 50.0 хүртэлх сая төгрөгний зээлийг олгохоор төсөл сонгон шалгаруулах шатандаа явж байна.	50
3.2.4	Малчид, тариаланчид, сумын төвийн өрхийн хамтын сан, хоршооны үйл ажиллагааг дэмжиж өрхийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлнэ	Зохион байгуулалтад орж дундын хуримтлалын сантай болсон бүлэг, хоршоо	Улирал бүр	1350	2500	Тосонцэнгэл сумын "Цохиот малчдын бүлэг", "Дашбалбар малчдын бүлэг"-үүд нь зохион байгуулалтад орж Ensure төслөөс 5.0 сая төгрөг, өөрсдийн хөрөнгөөр 1.5 сая төгрөгийг тус тус гарган дундын хуримтлалын сантай болсон байна. "Тосон дэлгэр эрдэнэ" хоршооны гишүүд 2022 онд 2.0 сая төгрөгийн дундын хуримтлал бий болгож 2023 онд Хоршоо хөгжүүлэх сангаас 20.0 сая төгрөгийн зээл авсан.	50
3.2 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН							50
3.3. ЭРҮҮЛ, ИДЭВХТЭЙ АМЬДРАЛ							
3.3.1	Хүн амд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн байгууллагын тоог нэмэгдүүлж, хамтын ажиллагааг сайжруулна	Шинээр ашиглалтанд орсон спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагын тоо	Жилд нэг удаа	43	70	Үндэсний бөхийн холбоо, Даян мэргэн харваачдын холбоо, аймгийн Дартсын холбоо, Хөл бөмбөгийн холбоо, Волейбол сонирхогчдын холбоо, Цогт фитнес клуб, Amka dance бүжгийн клуб, Монголын тусгай олимпын хороо, Ахмад шатарчдын холбоо Амар амьдрал ТББ -тай хамтран ажиллаж эдгээр байгууллагууд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Орон нутгийн хөгжлийн сангаас дэмжлэг үзүүлсэн.	50
3.3.2	Иргэдэд үйлчлэх нийтийн спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлнэ	Шинээр байгуулагдсан спортын гадна талбай, тоглоомын талбайгаар хэмжинэ	Жилд нэг удаа	23	50	Аймгийн сум бүрт хүүхдийн тоглоомын талбай, Улиастай сумын 6 багийн нутаг дэвсгэрт хүүхдийн тоглоомын талбай, сагсан бөмбөгийн талбайг байгуулан (60) хүүхэд тоглох, чөлөөт цагаа өнгөрөөх орчин бүрдсэн. Улиастай сумын Богдын гол багт "Соёл амралтын хүрээлэн" -нд сагс, волейбол, хөл бөмбөгийн талбай, дугуйн төрөл, дасгал хөдөлгөөн хийх талбайг байгуулж, нийтийн биеийн тамираар хичээллэх орчныг бүрдүүлж өдөртөө 100 -аас дээш тооны иргэд хамрагдаж байна. 2023 онд Залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, иргэд нийтээрээ агаар, салхинд байх ногоон орчныг бүрдүүлсэн "Гэрэлт гудамж" -ийг Улиастай сум ХС-ын 20,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийсэн. Улиастай сум хариуцан зохион байгуулж худалдаа үйлчилгээний цэгүүдийг байршуулсан байна.	90

3.3.3	Эрүүл зөв хооллох дадал, хэвшлийг бүх нийтэд түгээн дэлгэрүүлнэ	Чиглэлийн байгууллагаар үйлчлүүлсэн иргэдийн тоогоор хэмжинэ	Жилд нэг удаа	520	1250	“Эрүүл зан үйлийг хэвшүүлж-халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийг бууруулъя” 2 сарын аяныг өрнүүлж, 17832 иргэнд эрүүл хооллолт, идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэхийн ач тус, хүнсний бүтээгдэхүүний шошгын мэдээлэл уншиж суръя, бага насны хүүхдийн хоол тэжээл сэдвүүдийн хүрээнд зөвлөгөө мэдээлэл өгсөн. Сургалтын өмнөх болон дараах сорилоор 55,7 хувь нь эрүүл, зохистой хооллолтын талаар мэдлэгтэй, 70 хувь нь хоол, хүнсээр авбал зохих илчлэгийн хэмжээг тооцоолж мэдэхгүй гэсэн үнэлгээ гарсан. 1960 иргэний биеийн жингийн индексийг тодорхойлоход 77 хувь нь төвийн таргалалттай, 68 хувь нь илүүдэл жин таргалалттай, 2 хувь нь жин багатай үнэлэгдсэн. Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн сангийн 12 сая төгрөгийн санхүүжилтээр аймгийн Эрүүл мэндийн газарт хүүхэд хөхүүлэх орчныг бүрдүүлж, хүүхдийн өрөөг тохижуулан олон нийтэд сурталчлан, үйл ажиллагааг тогтмолжуулан ажиллаж байна. Эрүүл мэндийн сайдын албан даалгаврын дагуу ерөнхий боловсролын сургуулийн 27 дотуур байрны хүүхдийн хоолны илчлэг, шим тэжээлийн байдалд үнэлгээг хийхэд, дотуур байрны хүүхдийн хоолны дундаж илчлэгийн хэмжээ 1283 (1820-2700) ккал, уураг 55 (28-60) гр, өөх тос 32 (61-71) гр, нүүрс ус 191 (290-426) грамм байгаа нь хангалтгүй, өдөр бүр жимс, жимсгэнэ, сүү цагаан идээг өгч чадахгүй байна. Эрүүл мэндийн байгууллагуудын эмчилгээний хоолны чанар аюулгүй байдлыг сайжруулах аяны хүрээнд дагаж мөрдөх эрүүл ахуйн дадал, зонхилон тохиолдох өвчний үеийн эмнэл зүйн удирдамж сэдвээр тогооч, нярав, эмч нарыг сургалтад хамруулж, сургалтын дараах сорилоор мэдлэг олголтын түвшин 30 хувиар дээшилсэн. Эмчилгээний хоолны дундаж илчлэгийг үнэлэхэд 1353 ккал гэж үнэлэгдсэн. Эрүүл мэндийн байгууллагын тогооч нарыг (26 хувь) ажлын байрны чадавхжуулах 5 хоногийн сургалтад хамруулсан байна.	90
3.3.4	Нийгмийн хамгааллын суурь хөтөлбөрт хамрагдаж буй иргэдийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна	Хамрагдсан иргэд	Жилд нэг удаа	58%	82%	Нийгмийн даатгалд 14789 хүнийг хамруулан 72,1 тэрбум төгрөг, Нийгмийн халамжийн үйлчилгээнд 27960 иргэнийг хамруулан 11.1 тэрбум төгрөг тус тус зарцуулсан байна. Нийгмийн хамгааллын суурь хөтөлбөрт нийт 42749 иргэнийг хамруулан үйлчилгээг үзүүлсэн байна.	100
3.3.5	Зорилтот бүлгүүдэд чиглэсэн амралт, сувиллын газруудын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ	Хамрагдсан иргэдийн тоо	Жилд нэг удаа	500	2000	15 рашаан сувилалд 605 ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэн хамрагдаж халамжийн сангаас 102.8 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн байна. Үүнээс аймгийн "Чигэстэй ундараа" ХХК -ний Улаан хаалга дахь рашаан сувилал 199 иргэн 39 сая, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дэргэдэх "Ахмадын сувилал" нь 315 иргэн 47,2 сая, Үе залгамжлагч сувилал нь 18 иргэн 3.4 сая төгрөг, улсын хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж буй 12 рашаан сувилал 13.4 сая төгрөгийн санхүүжилтийг авсан байна.	100
3.3.6	Бие бялдрын сорилыг чанартай зохион байгуулж, хамрах хүрээг нэмэгдүүлнэ	Сорилд хамрагдалтын хувь	Жилд нэг удаа	17.6%	73.5%	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 5-аас дээш насны хүүхдүүд, төрийн болон аж ахуй нэгж байгууллагын албан хаагчдыг хамруулан бие бялдрын түвшин тогтоох сорилыг жил бүрд авч байна. 2023 оны 11 дүгээр сарын байдлаар 18000 хүн хамрагдсанаас 10000 –ийг хүн амын бие бялдрын түвшин тогтоох сорилын нэгдсэн программд мэдээллийг оруулсан. Зорилтод хүн амын 35 хувийг хамруулсан мэдээлэл байна.	70
3.3 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН							83.33
3.4.	ХҮНД ЭЭЛТЭЙ ОРЧИН						
3.4.1	Өрхийн худалдан авах чадварт нийцсэн хямд өртөг бүхий орон сууцаар хангахад дэмжлэг үзүүлнэ	Орон сууцаар хангагдсан өрхийн тоо	Жилд нэг удаа	50	100	2022 онд Их-Уул, Тэлмэн, Идэр сумдад тус бүр 12 айлын орон сууц, Улиастай сумын Богдын гол багт "Жинст багт "Оч-Дөл өлзийт" ХХК-ний 25 айлын орон сууцны барилгууд тус тус ашиглалтад орсон. 2023 онд Жинст багт үйлчилгээтэй 17 айлын орон сууц Богдын гол багт Иргэн Баярмаагийн 12 айлын орон сууцны барилга тус тус ашиглалтад орсон. Мөн Шинээр Алтанхарш ХХК 13 айлын орон сууц Оч дөл өлзийт ХХК-ний 15 айлын орон сууц, Иргэн Хатбаатарын 25 айлын орон сууц, Арь констракшн ХХК-ний 25 айлын орон сууц Иргэн Гомбодоржийн 12 айлын орон сууц, Зүр өргөө ХХК-ний 48 айлын орон сууц, Нөмрөг, Сонгино, Түдэвтэй сумдад тус бүр 12, нийт 164 айлын орон сууцны барилга угсралтын ажил хийгдэж байна. Улиастай сумд 21-р зуун 800 айлын жишиг хорооллын инженерийн шугам сүлжээг /цэвэр, бохир, дулаан, цахилгаан эрчим хүч/ 2023 онд үргэлжлүүлэн хийж байна. Шинээр байгуулах тус хорооллын шугам сүлжээний ажлыг хийж дууссаны дараа хувийн аж ахуйн нэгжийн санхүүжилтээр хямд өртөгтэй орон сууцны барилга баригдах боломж бүрдэнэ. Улсын төсвийн 2.5 тэрбум төгрөгийн санхүүжилтээр инженерийн шугам сүлжээг гүйцэтгэж байна.	70
3.4.2	Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувийг нэмэгдүүлнэ.	Хүн амын эзлэх хувь	Жилд нэг удаа	70%	85%	Шилүүстэй сумын гүний худаг 2022 оны 6 сард 120 сая төгрөгийн өртөг бүхий хоногт 2тонн ус шүүх хүчин чадалтай шүүлтүүр шинээр суурилуулан ажиллаж байна. 2022 онд Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн сангийн санхүүжилтээр Завхан аймгийн шугамд холбогдсон ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байранд нийт 162 ус цэвэршүүлэх, суурилуулсан. 2023 онд Цагаанчулуут сумд 80 сая төгрөгийн өртөг бүхий ундны усны эх үүсвэрт цэвэршүүлэх төхөөрөмж суурьлуулахаар ажил тэндэр зарлагдсан байна. Түдэвтэй сумын шинэ суурьшлын бүсд ОНТ-ийн 50.0 сая төгрөгийн санхүүжилтээр шинээр 1 худаг гаргаж, ухаалаг төлбөрийн систем суурилуулж байна.2022 онд 10 сая төгрөгийн санхүүжилтээр 16 сумын усны сан бүхий газарт самбар, тэмдэг тэмдэглэгээ суурилуулах ажил хийгдэж байна. Мөн Эрдэнэхайрхан сумын ундны усны худагт гадна цахилгаан эрчим хүч татах ажилд 20.0 сая төгрөгийн санхүүжилт шийдвэрлэж, ажлыг хийж ашиглалтад оруулсан. Улиастай сумын гэр хорооллын айл өрхийн усан хангамжийг нэмэгдүүлэх ажлыг Амь-Ус ХХК-тай гэрээ байгуулан ажил эхэлсэн. Цэгт чандмань дрийлэн ХХК худаг засварлах ажлыг хийж гүйцэтгэсэн.	50

3.4.3	Инженерийн бүрэн хангамжтай орон сууцаар хангагдсан өрхийн нийт өрхөд эзлэх хувийг нэмэгдүүлнэ.	Өрхийн эзлэх хувь	Жилд нэг удаа	24%	30%	Улиастай сумд 21-р зуун 800 айлын жишиг хорооллын инженерийн шугам сүлжээг /цэвэр, бохир, дулаан, цахилгаан эрчим хүч/ 2021 онд үргэлжлүүлэн хийж байна. Шинээр байгуулах тус хорооллын шугам сүлжээний ажлыг хийж дууссаны дараа хувийн аж ахуйн нэгжийн санхүүжилтээр хямд өртөгтэй орон сууцны барилга баригдаж эхэлнэ. Улсын төсвийн 2.5 тэрбум төгрөгийн санхүүжилтээр инженерийн шугам сүлжээг гүйцэтгэж байна. 2022 онд Их-Уул, Тэлмэн, Идэр сумдад тус бүр 12 айлын орон сууц, Улиастай сумын Богдын гол багт "Жинст багт "Оч-Дөл өлзийт" ХХК-ний 25 айлын орон сууцны барилгууд тус тус ашиглалтад орсон. 2023 онд Жинст багт үйлчилгээтэй 17 айлын орон сууц Богдын гол багт Иргэн Баярмаагийн 12 айлын орон сууцны барилга тус тус ашиглалтад орсон. Мөн Шинээр Алтанхарш ХХК 13 айлын орон сууц Оч дөл өлзийт ХХК-ний 15 айлын орон сууц, Иргэн Хатбаатарын 25 айлын орон сууц, Арь констракшн ХХК-ний 25 айлын орон сууц Иргэн Гомбодоржийн 12 айлын орон сууц, Зүр өргөө ХХК-ний 48, Нөмрөг, Сонгино, Түдэвтэй сумдад тус бүр 12 айлын орон сууц, нийт 164 айлын орон сууцны барилга угсралтын ажил хийгдэж байна.	50
3.4.4	Аймаг, сумын төвийн өрхүүдээс нэгдсэн халаалтанд холбогдсон өрхийн тоог нэмэгдүүлнэ.	Халаалтанд холбогдсон өрхийн эзлэх хувь	Жилд нэг удаа	12%	20%	Аймгийн хэмжээнд 19 сум нь 2014-2020 оны хооронд нэгдсэн дулааны эх үүсвэрт холбогдсон дулааны шугамтай зэрэгцэн цэвэр усны ундны эх үүсвэрт холбуулаад байна. 2024 онд дулааны станц ашиглалтанд орохтой холбогдуулан нэгдсэн халаалтанд холбогдох өрхийн тоо нэмэгдэнэ. Сумдыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын тендер барилга хот байгуулалтын яаманд тендер зарлагдаж Сонгино Түдэвтэй сумыг Сонголт дизайн ХХК, Тэс Цагаанхайрхан сумын зураг төслийг Консалтинг ХХК, Дөрвөлжин сумыг Инженер геодези ХХК тус тус гүйцэтгэгчээр шалгарсан боловч төсвийн тодотголоор хөрөнгө хасагдсан. 2021 онд төвлөрсөн дулаан, цэвэр усны шугам сүлжээнд Яруу сумд холбогдож, 2022 онд төвлөрсөн дулаан, цэвэр усны шугам сүлжээнд Их-Уул сум холбогдож, ашиглалтад орсоноор Завхан аймгийн 23 сум төвлөрсөн дулаан, цэвэр усны шугам сүлжээнд холбогдлоо. Шинэ сум төслийн хүрээнд Отгон сумд төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ хийгдэж байна. Айл өрх, албан байгууллагуудыг төвлөрсөн шугам сүлжээнд холбох боломж нөхцөл бүрдээд байна. Завхан аймгийн Улиастай суманд 25 Гкал/цаг хүчин чадалтай дулааны станцын барилгын ажлыг эхлүүлээд байна. БНСУ-ын 13 сая 95 мянган америк долларын хөнгөлөлттэй зээлээр 8.4 км дулааны шугам, 11 дулаан дамжуулах төв баригдахаар төлөвлөгдөж Төслийн ерөнхий гүйцэтгэгчээр БНСУ-ын "Бюксан инженеринг" ХХК, туслан гүйцэтгэгчээр "МЭЗ" ХХК шалгарч 2024 оны намар ашиглалтад оруулахаар барилга угсралтын ажил хийгдэж байна. Дулааны станцын 2-р хэлхээ, Зураг төсөв магадлангаар орж баталгаажсан нийт 19,742,274,884 төгрөгийн төсөвт өртөгтэй. 2024 оны төсөвт суулгахаар санал хүргүүлсэн байна.	70
3.4.5	"Шинэ сум" төслийг хэрэгжүүлж, сумын төвүүдийг стандартад нийцсэн ус, ариун цэврийн байгууламжтай болгоно	Байгууламжийн тоо	Жилд нэг удаа	3	6	Сумын төвийн шинэчлэл төслийн хүрээнд 2023 онд Алдархаан, Отгон суманд үлдэгдэл санхүүжилтийг шийдвэрлэж Отгон сум 50м3/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламж ашиглалтад оруулсан. Польшийн хөрөнгө оруулалтаар Завхан аймгийн Жинст багт баригдаж буй бохир ус цэвэрлэх байгууламж нь 3000м3/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн барилга инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажлын төсөвт өртөгийн дүн нь 18,758,067,912 төгрөг. Лагийг боловсруулж бордоо гаргах, бохир усыг 90 гаруй хувьтай цэвэрлэх бөгөөд хүчин чадал нь одоогийнхоос 3 дахин нэмэгдэж, байгальд ээлтэй, орчин үеийн агааржуулалтын системтэй, автоматжуулсан цэвэрлэх байгууламж юм. Барилгын ажлын гүйцэтгэгч нь: Ерөнхий гүйцэтгэгч: ABI&SWT Консорциум Туслан гүйцэтгэгч: Сайн конштракш ХХК гүйцэтгэж байна. 2022 онд Аймгийн хэмжээнд сургууль, цэцэрлэг, дотуур байрны барилгын нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих ажлын хүрээнд 13 сум хамрагдсан үүнээс 8 сумын сургууль, цэцэрлэг дотуур байрны барилгын ариун цэврийн байгууламжийн ажлыг хүлээлцэх комисс ажиллаж, ашиглалтад оруулсан. Улиастай сумын Жинст багийн Дулааны станцын 2-р хэлхээ, Зураг төсөв магадлангаар орж баталгаажсан нийт 19,742,274,884 төгрөгийн төсөвт өртөгтэй. Эрчим хүчний сайдын багцад Дулааны станцын ариутгах татуурга, цэвэр усны шугам, холбоо дохиоллын ажлыг төсөв тусгуулахаар саналыг хүргүүлсэн.	50
3.4.6	Сум, суурин газруудын ногоон байгууламжийн эзлэх талбайг нэмэгдүүлж, соёл амралтын хүрээлэн байгуулна.	Ногоон байгууламжийн талбай	Жилд нэг удаа	12.6	38.0	Аймгийн хэмжээнд хавар намрын мод тарих үндэсний өдрөөр төв суурин газарт 30 мянган ширхэг тарьц суулгац тарьж, Идэр голын сав газрын дагуу 4 га талбайд ойн төгөл байгуулсан. Мөн 2021 онд Гудамж төслийн хүрээнд Улсын төсвийн 1.2 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Улиастай сумд 4 га газарт ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн, соёл амралтын хүрээлэн байгуулсан. 2023 онд Улиастай хотын төв талбайг шинэчилж тохижилт, 0.5 га ногоон байгууламж шинээр хийсэн. Улиастай хотын Богдын гол хүүхэд залуучуудын соёл амралтын хүрээлэнг ОНТ-ийн 649.9 сая төгрөгийн санхүүжилтээр засвар хийж, ногоон байгууламж байгуулсан.	30
3.4.7	Нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна	Үйлчилгээгээр хангагдсан иргэдийн хувь	Жилд нэг удаа	2%	25%	2022 онд ОНХС-ийн 80 сая төгрөгийн санхүүжилтээр бага оврын 1 автобус авсан. 2023 онд ОНХС-ийн 120.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Улиастай сумын хүүхдийн автобус авах ажилд "Жинчин гранд" ХХК шалгарч, HUYNDAI COUNTY загварын бага оврын автобус нийлүүлсэн.	90

3.4.8	Үерийн эрсдэлээс хамгаалагдсан өрхийн тоог нэмэгдүүлнэ	Байгууламжийн тоо	Жилд нэг удаа	0	3	2022 онд Завханмандал сумын төвийн үерийн усны даланг ОНТ-ийн 40.0 сая төгрөгийн санхүүжилтээр засвар шинэчлэлт хийсэн. 2023 онд Улиастай сумын Богдын гол багийн үерийн усны даланг ОНТ-ийн 25.0 сая төгрөгийн санхүүжилтээр засвар хийсэн. 2021 онд Барилга хот байгуулалтын сайдын багцаас хөрөнгө батлагдаж Жаргалант, Чигэстэй багт 5км үерийн усны далан байгуулах ажлын зураг төсөв боловсруулах ажлын даалгавар хүргүүлж төрийн худалдан авах ажиллагааны газарт тендер зарлагдаж "Гидросоружение" ХХК шалгарч ажлын зураг төслийг гүйцэтгэж БХБЯ-нд хүлээлгэн өгсөн. Тус далангийн ажлыг гүйцэтгэхэд 8.5 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай бөгөөд батлагдсан зураг төсвийн дагуу хөрөнгийн асуудлыг шийдвэрүүлэхээр 2023, 2024 оны Улсын төсөвт хөрөнгийн асуудлыг шийдвэрүүлэхээр БХБЯ-нд санал хүргүүлсэн.	30
3.4 ДҮГЭЭР ЗОРИЛТЫН ДҮН							55
3.5.	ГАЗРЫН ХАРИЛЦАА						
3.5.1	Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулна.	Төлөвлөгөө боловсруулагдсан сумын тоо	Жилд нэг удаа		3	2018-2020 онд "Шинэ сум" төслийн хүрээнд Алдархаан, Отгон сумдын сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хийлгэсэн. Мөн Улиастай хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг "Некст инженеринг" ХХК -аар хийлгэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулан хүлээн авсан. 2022 онд Цэцэн-Уул сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг ОНТ-өөр хийсэн. 2023 онд Улсын төсвийн санхүүжилтэд 5 сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдсан боловч төсвийн тодотголоор хасагдсан. 2024 оны УТ, ОНТ-т 5 сумд ЕТ хийлгэхээр санал хүргүүлсэн.	30
3.5.2	Газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл, үнэлгээ, төлбөр, татвар, биржийн системийг хөгжүүлнэ	Зах зээлийн үнийн мэдээ болон газрын дуудлага худалдааны тоо	Жилд нэг удаа	823	5851	Газрын цахим бирж www.mle.mn сайтаас ашиглах 2022 онд 197 дуудлага худалдаа зохион байгуулж аймгийн төсөвт 402.9 сая төгрөг төвлөрүүлсэн бол 2023 онд 122 нэгж талбарт дуудлага худалдаа зохион байгуулахаар төлөвлөж 75 нэгж талбарт 3520 га газрын дуудлага худалдааг амжилттай зохион байгуулан 190.8 сая төгрөгийг төвлөрүүлээд байна. Мөн 1359 зах зээлийн үнийн мэдээг цахим биржид байршуулсан байна. Энэ онд 11867 нэгж талбарт 1,014 тэр бум төгрөгийн ногдуулалтыг үүсгэж, 11 сарын 1-ний өдрийн байдлаар 48.9 хувийн төлөлттэй байна. 2023 оны байдлаар 25381 нэгж талбар байгаагаас өмчлөлийн мэдээллийн системд бүртгэгдсэн 7571 нэгж талбар, эзэмшлийн 8379 нэгж талбар мэдээллийн санд Э дугаар авч бүртгэгдсэн байна.	70
3.5.3	Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан бүсчилсэн хөгжлийн бодлого, бүс нутгийн оновчтой бүтэц, хөгжлийн ирээдүйтэй сууринг тодорхойлж, орон зайн төлөвлөлтийг боловсруулна.	Төлөвлөлтөнд орон зайн төлөвлөлт ашигласан сум, байгууллагын тоо	Жилд нэг удаа	17	41	Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл" боловсруулах сургалтад холбогдох мэргэжилтнийг оролцуулсан. Мөн "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл" боловсруулах ажлын хэсгийг орон нутгийн зүгээс мэдээллээр ханган ажиллалаа. 2019 оны 05 дугаар сард БХБЯ, Барилгын хөгжлийн төвийн Хүн амын нутагшилт суурьшлын бүс нутгийн төлөвлөлтийн хэлтсээс төслийн бүрэлдэхүүн ирж аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын хурлын зааланд холбогдох байгууллага, албан тушаалтан 54 хүнийг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэлэлцүүлгээр төслийн талаар танилцуулж төсөлд оруулах саналыг орон нутаг нэгтгэн гаргаж өгсөн. Ажлын хэсгийг холбогдох мэдээлэл судалгаагаар хангах үүднээс орон нутгийн холбогдох байгууллагуудаас 35 төрлийн хүснэгтийн дагуу судалгаа гаргуулж нэгтгэн хүргүүлсэн. Улсын хэмжээнд хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл" боловсруулах ажил хийгдэж дууссан. УИХ-р батлуулах ажил хүлээгдэж байна.	70
3.5.4	Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг үе шаттай боловсруулна	Сумын тоо	Жилд нэг удаа	3	6	2022 онд "Уур амьсгалын өөрчлөлтөд монгол орны хөдөөгийн иргэдийн дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг сайжруулах нь" төсөлтэй хамтран Алдархаан, Эрдэнэхайрхан, Отгон зэрэг 8 сумд нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажлыг БОАЖЯ тендерийг зарлаж "Лап ланд эко" ХХК шалгарч гүйцэтгэсэн. 2023 онд тус төслийн санхүүжилтээр 13 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулсан. Завхан аймгийн 24 сум нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөтэй болсон.	90
3.5.5	Сумдад хаягжилтын нэгдсэн системийг нэвтрүүлнэ	Стандартын хаягжилт хийгдсэн өрхийн тоо	Жилд нэг удаа	14	24	2021 онд хаягийн мэдээллийн цахим системийг 24 суманд нэвтрүүлж, бүртгэлтэй бүх нэгж талбар барилгын хаягийг баталгаажуулсан. Нийт 15 суманд хашаа болон гудамжны хаягийн суурилуулалтын ажил хийгдсэн. Хаягийн зураг, мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг 2017 онд хүлээн авснаас хойш сумдууд хаягийн зураг, мэдээллийн сангийн шинэчлэлт дутуу хийгдэх, тусгай барилга, байгууламжууд үсгэн болон тоон тэмдэглэгээгээр хаяглагдаагүй, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор батлагдаагүй гудамжны нэр, дугаарыг хаягийн зурагт оруулсан, орон нутгийн сонгуулийн дараа гудамжны нэрийг өөрчлөх тохиолдол гарсан бөгөөд зохих өөрчлөлтийг тухай бүр хаягийн мэдээллийн санд оруулахгүй байх зэрэг нийтлэг зөрчил их байгаатай холбогдуулан хаягийн мэдээлэл шалгах, засварлах ажлын төлөвлөгөөний дагуу удирдамж гарган 24 сумын хаягийн мэдээллийн санг барилга 82.5, нэгж талбар 78.1 хувьтай хийгдэж байна.	70
3.5 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН							66
ГУРАВДУГААР БҮЛГИЙН ДҮН							62.12
ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСАГ							
4.1	БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР						

4.1.1	Макро эдийн засгийг хөгжлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг эрчимжүүлнэ	Хувиар	Жилд нэг удаа	7%	3%	Ургац хураалтын явцын мэдээгээр аймгийн хэмжээнд 2023 оны 8 дугаар сарын 30-ны байдлаар 1259.1 тонн хадлан бэлтгэж, 52.0 тонн төмс, 62.9 тонн хүнсний ногоо, 45.0 тонн таримал тэжээл хураан аваад байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад төмс 6.1 (10.5%) тонн, хүнсний ногоо 14.0 (18.2%) тонн, бэлтгэсэн хадлан 181.9 (12.6%) тонноор тус тус буурч, таримал тэжээл 7.0 (18.4%) тонноор өссөн байна. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 104.2 тэрбум төгрөг болсон ба нийт үйлдвэрлэлийн 84.9 хувийг уул уурхайн олборлолт, 10.4 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 3.7 хувийг цахилгаан, дулааны үйлдвэрлэл, 1.0 хувийг бусад үйлдвэрлэл эзэлж байна.	50
4.1.2	Орон нутгийн эдийн засгийн бүтцийг шинэчлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулна	Эдийн засгийн салбаруудын бүтэц ДНБ-д эзлэх хувиар хэмжинэ	Жилд нэг удаа	32.5%	48.0%	Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2023 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр 104.2 тэрбум төгрөг болсон байна. Нийт үйлдвэрлэлийн 84.9 хувийг уул уурхайн олборлолт, 10.4 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 3.7 хувийг цахилгаан, дулааны үйлдвэрлэл, 1.0 хувийг бусад үйлдвэрлэл эзэлж байна	50
4.1.3	Орон нутгийн татварын орлогыг нэмэгдүүлнэ	Төсвийн орлого	Жилд нэг удаа	7,670	9,858	2023 оны эхний 11 сарын байдлаар орон нутгийн татварын нийт орлого төлөвлөгөөгөөр 14167,9 сая төгрөгнөөс 16447,9 сая төгрөгний орлого орж татварын орлого 2280,0 сая буюу 106,0 хувиар давж биелсэн байна. Аймгийн төсвийн орлого 4089,6 сая төгрөгнөөс 3018,5 сая төгрөгний орлого орж 1071,1 сая төгрөгөөр тасарч, сумдын төсвийн орлого 10078,2 сая төгрөгнөөс 13429,4 сая төгрөг орж 3351,2 сая төгрөгөөр давж биелсэн байна.	100
4.1.4	Төсвийн үр ашигтай, ил тод, шуурхай байдлыг хангуулна	Төсвийн зардал	Жилд нэг удаа	22,152	22,747	2023 оны эхний 11 сарын байдлаар орон нутгийн төсвийн зарлага төлөвлөгөөгөөр 67228,9 сая төгрөгнөөс 53945,3 сая төгрөгний зарлага гарсан байна.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу хэмнэгдэх зардлуудыг хэмнэж ажилласан.	70
4.1.5	Үйлдвэрийн аргаар боловсруулсан махны хэрэглээ, экспортыг нэмэгдүүлнэ.	Үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ	Жилд нэг удаа	3,094.50	5,453.57	Завхан аймгийн хэмжээнд "Завхан хүнс" групп, "Завхан Мах маркет" ХХК, "Баян ньуу фүүд центури" ХХК, Нисэх агро ХХК, "Сэцэн Агро" ХХК, "Тэс –Шим" хоршоо зэрэг 6 аж ахуйн нэгж мах боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж бөгөөд бие даасан экспортын гэрээ хийсэн аж ахуй нэгж байхгүй. 2023 оны статистик мэдээгээр мах, махан бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрийн борлуулалтын орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26,9% өссөн үзүүлэлттэй байна.	90
4.1.6	Орон нутаг дахь үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү, сүүн бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлнэ.	Үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан сүү, сүүн бүтээгдэхүүний борлуулалтаар хэмжинэ	Жилд нэг удаа	4,373.60	7,043.73	Хүн амын хүнсний хэрэгцээнд хөдөө аж ахуйгаас 27.2 мянган литр сүү, 5.4 тн цагаан идээ хүн амын хүнсний хэрэгцээнд нийлүүлсэн байна. Сүүний чиглэлийн эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч 11 сумын 37 иргэн аж ахуйн нэгж жилд дунджаар 310.8 тн сүү бэлтгэн зах зээлд нийлүүлж нийт хүн амын сүүний хэрэгцээний 3.2%-ийг хангаж, хөдөө аж ахуйгаас 62.8 хувийг өрхийн үйлдвэрлэлийн түвшинд бэлтгэгдсэн сүү цагаан идээгээр хангаж байна. Аймгийн Засаг дарга сумдын Засаг дарга нартай байгуулсан 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хөдөө аж ахуйгаас бэлтгэн нийлүүлэх сүү, цагаан идээний хэмжээг тусган хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. Сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ 2023 онд 22.5 буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.4 хувь өссөн байна.	90
4.1.7	Малын гаралтай бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	Малын гаралтай бүтээгдэхүүний борлуулалтын орлого	Жилд нэг удаа	23,247	37,716	Аймгийн хэмжээнд арьс шир боловсруулах, ноос, эсгий үйлдвэрлэх чиглэлээр 9 суманд 2 аж ахуй нэгж, 6 хоршоо, 13 иргэн үйл ажиллагаа явуулж байна. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 75 тэрбум 539.5 сая төгрөг, үүний 13.1 хувийг боловсруулах үйлдвэрлэл эзэлж борлуулалт 9 тэр бум 820.1 сая төгрөгт хүрсэн байна.	90
4.1.8	Орон нутгийн барилгын материалын нөөцөд тулгуурласан хөнгөн үйлдвэрүүдийг байгуулж, борлуулалтын сүлжээг бий болгоно.	Орон нутагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээр хэмжинэ	Жилд нэг удаа	2,436	4,899	2021 онд Алдархаан сумын шохойн чулууны нөөцийг түшиглэж Улиастай сумд ханын дүүргэгч материал болох хөнгөн блокны үйлдвэрлэлийг хувийн аж ахуйн нэгж үйлдвэрлэж, эхэлсэн боловч ковид-19 цар тахлын улмаас зогсолт хийгээд байна. 2022 онд Улиастай сумын Агьт аманд стандартын шаардлага хангасан хайрга, дайрга үйлдвэрлэх 2 үйлдвэр байгуулж, мөн Өлзийт багт хоногт 1000м3 зуурмаг нийлүүлэх хүчин чадалтай зуурмагийн үйлдвэр шинээр байгуулсан. Мөн ханын дулаалга хөөсөнцөр хавтангийн үйлдвэр, явган замын хавтан хашлага, ханын дүүргэгч блок, төмөр бетон эдлэлийн үйлдвэрүүд ажиллаж байна.	50
4.1 ДҮГЭЭР ЗОРИЛТЫН ДҮН							73.75
4.2	БИЗНЕС ЭРХЛЭХ ТААТАЙ ОРЧИН						
4.2.1	Аймгийн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ	Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ	Жилд нэг удаа	25,980	39,281	2023 онд аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ буурсан үзүүлэлттэй байгаа ч боловсруулах үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүний хэмжээ 2022 оны мөн үетэй харьцуулахад 0,39% өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн тэр дундаа нарийн боовны үйлдвэрлэлийн хэмжээ 4,79%, цөвэр усны үйлдвэрлэл 2,1% өссөн үзүүлэлттэй байна. Баталгаажуулалтын зөвлөлийн хурлын шийдвэрээр энэ оны 10 сарын байдлаар 23 сумын 201 иргэн, аж ахуйн нэгж, үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнд баталгаажуулах үйл ажиллагааг хийж, баталгаажуулалтын зөвлөлийн 12 удаагийн хурлаар 182 аж ахуй нэгж, 17 бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээ олгож үйл ажиллагаа хигдэрсэн байна.	70

4.2.2	Орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг нийлүүлэх тээвэр, логистикийн төвүүдийг томоохон хотуудад байгуулна	Байгуулагдсан агуулах худалдааны төвөөр дамжуулан борлуулсан бүтээгдэхүүний хэмжээ	Жилд нэг удаа	0	400.0	2022 онд Улиастай суманд ЭмАрЭм Эс ХХК нь 500м2 талбай бүхий Баян бүрд агуулах ашиглалтад орж бусад сумдад хүнс, өргөн хэрэглээний бөөний бараа бүтээгдэхүүнийг агуулахаас шууд тээвэрлэх боломж бүрдсэн. Тосонцэнгэл сумын Мөнх өвөгдий ХХК үйл ажиллагаагаа өргөжүүлж Өвөгдий худалдааны төв үйл ажиллагаа эхлүүлэн хэрэглэгчдэд бараа бүтээгдэхүүн худалдан авах таатай нөхцөлийг бий болгосон	0
4.2.3	Орон нутгийн давуу талыг түшиглэн зэргэлдээ улс, аймгуудад бүтээгдэхүүн нийлүүлэх сувгийг өргөжүүлнэ.	Хөрш зэргэлдээ улс, аймгуудтай хийсэн худалдааны хэлэлцээр, гэрээ, бий болсон сувгийн тоо	Жилд нэг удаа	0	15	Орон нутгийн брэнд бүтээгдэхүүн борлуулдаг Завханд үйлдвэрлэв онлайн дэлгүүр Хүннү зоогийн газрын танхимд 13 аж ахуйн нэгж үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүнийг борлуулж байна. "Мөнхөд Мандаг" ХХК Номин сүлжээ дэлгүүртэй брэнд бүтээгдэхүүнээ борлуулах гэрээ хийн борлуулж байна. Улиастай суманд ЭмАрЭм Эс ХХК 500м2 талбай бүхий Баян бүрд агуулах худалдаа үйл ажиллагаа эхлүүлсэн . Тус компани нь Витафит, АПУ гэх мэт 6 аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан бөөний үнээр сумдын худалдаа эрхлэгчдэд хүнс, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг худалдаалж байна.	70
4.2.4	Гамшгийн үеийн эдийн засгийг тогтворжуулж, хувийн салбарын санхүүгийн чадамжийг дээшлүүлнэ	Санхүүжилтийн хэмжээ	Жилд нэг удаа	50	500	Завхан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 28 дугаар "Аймгийн 2022 оны төсөв батлах тухай" тогтоолоор аймгийн Засаг даргын нөөц санд 1,365,200,000 төгрөг. Үүнээс Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 20 –ны өдрийн 61 дугаар тушаал "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.1, 2.1.2 дугаар заалтад заагдсан арга хэмжээнд зарцуулах 409,560,000 төгрөг тусгагдсан. Мөн аймаг, сумын 2022 оны төсөвт гамшгаас урьдчилан сэргийлэх, онцгой байдлын байгууллагын чадавхыг дээшлүүлэх хүрээнд нийт 90,340,000 төгрөгийн төсвийг тусгуулсан байна.Улсын Онцгой комиссын ажлын албанд хагас бүтэн жилээр хөрөнгө зарцуулалтын тайланг гаргаж хүргүүлэн ажиллаж байна.	70
4.2 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН							52.5
4.3	БРЭНД БҮТЭЭГДЭХҮҮН						
4.3.1	Технологи, мэдээллийн паркад суурилсан ХАА, барилгын салбар, биотехнологийн туршилтийн лаборатори байгуулахад дэмжлэг үзүүлнэ	Туршилтаар хийгдсэн бүтээгдэхүүний тоо	Жилд нэг удаа	0	25	Хөдөө аж ахуйн их сургуультай хүний нөөц, тоног төхөөрөмж, эрдэм шинжилгээ судалгаа хийх шинэ технологи инновацын бүтээгдэхүүн хөгжүүлэх ажилд хамтран ажиллах санамж бичиг байгуулан ажиллаж байна. Аймгийн Политехник коллежид барилгын засал чимэглэл, мужаан, сантехник, цахилгаанчны чиглэлээр 2023 онд 61 хүүхэд тус мэргэжлээр төгсөж 62 хүүхэд тус мэргэжлээр суралцаж байна.	30
4.3.2	Орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн түвшинд хөгжүүлнэ	Завхан аймгийн брэнд бүтээгдэхүүний хөгжүүлэлт, технологижуулалтад зарцуулсан хөрөнгө оруулалтын хэмжээ	Жилд нэг удаа	400	1,200	100 жилийн ойг тохиолдуулан Call Center үйлчилгээ нэвтрүүлж аймгийн брэнд бүтээгдэхүүн, үйлдвэрлэл үйлчилгээний нэгдсэн мэдээллийн сувгийг бий болгосон аппликейшн боловсруулалтын ажил хийгдэж байна. zavkhan brend.com цахим флатформ хөгжүүлэлтийн эрх нээгдсэн бараа бүтээгдэхүүн байршуулах боловсруулалтын ажил хийгдэж байна.	50
4.3.3	Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжинэ	Худалдан авалтад эзлэх хувь	Жилд нэг удаа	12%	50%	2022 онд орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн худалдан авах ажилд 2 ажил арга хэмжээний 80.834.000 төгрөгийн худалдан авалт хийсэн байна. 2023 онд 3 ажил арга хэмжээний нийт 142.800.900 төгрөгийн худалдан авалт хийсэн байна.	50
4.3.4	Дахивар бүтээгдэхүүн худалдан авах цэгүүд, боловсруулах цех байгуулна	Боловсруулсан бүтээгдэхүүний хэмжээ	Хагас жилд нэг удаа	0	50	2023 оны 05 сард "Ногоон Улиастай төв" хог хаягдлыг боловсруулах үйлдвэр үйл ажиллагаагаа эхлүүлж (гялгар уут, ундааны сав) хуванцар худалдан авч хуванцар сандал, худгийн таг, хуванцар шон зэргийг үйлдвэрлэж байна.	50
4.3 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН							45.00
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛГИЙН ДҮН							57.08
ТАВ. ЗАСАГЛАЛ							
5.1	УХААЛАГ ЗАСАГЛАЛ						

5.1.1	Ухаалаг системд суурилсан төрийн үйлчилгээг иргэдэд хүргэнэ	Төрийн үйлчилгээг цахимаар авсан иргэдийн хувь	Жилд нэг удаа	15%	60%	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын харьяа завхан аймаг дахь төрийн цахим үйлчилгээний хэлтэс шинээр байгуулагдаж операторын горим болон киоск машин, утасны аппликейшнаар үйлчилгээ хүргэх цэгүүдийн тоог нэмэгдүүлж, цахим үйлчилгээний талаарх мэдээллийг олон нийтэд сурталчлах, танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан. "Шинэ сэргэлтийн бодлого"-д тусгагдсан Төрийн бүтээмжийг сайжруулах шинэчлэлтийг хэрэгжүүлэх, төрийн байгууллага цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх шаардлагыг тогтоох, байгууллага, албан тушаалтан иргэнтэй шууд харьцах замаар үйлчилгээ үзүүлдэг байдлыг халах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэх зорилгоор Улиастай,Тосонцэнгэл сумдад ОНТ,ОНХС-ын санхүүжилтээр "Хурдан" цэгийг байгуулж, Улсын бүртгэлийн хэлтэс, ГХБХБГ-аар киоск машинаар болон Баруун бүсийн худалдааны төв, Нэгдсэн эмнэлэг, Шуудан үйлчилгээний газар, 24 сумын ЗДТГ-ын оператороор давхардсан тоогоор 15000 иргэдэд цахим үйлчилгээ үзүүлсэн. Мөн аймгийн 100 жилийн ойгоор иргэдийн санал хүсэлтийг хүлээж авах, иргэд, байгууллагыг холбох зорилго бүхий call center байгуулан амжилттай ажилласан.	70
5.1.2	Төрийн албан хаагчдыг цахим хэрэглэгдэхүүн ашиглан чадавжуулна	Төрийн байгууллагын тоо	Жилд нэг удаа	5	42	Цахим хөгжил, харилцаа холбооны яам, И Монгол академитай хамтран Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн ер.е.mongolia портал системийг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж аймгийн Засаг даргын Тамгын газар болон хэлтэс агентлаг нэвтрүүлсэн бол 2023 онд 24 сумдын 100 гаруй байгууллага тус системтэй холбогдож, төрийн албан хаагчдыг цахим систем, хэрэглэгдэхүүн ашиглах сургалтад ээлж дараатайгаар хамруулж, гарын авлага, мэдээллээр ханган, заавар зөвлөгөө өгч байна. Мөн албан бичиг солилцооны дундын docX системд байгууллагууд ээлж дараатай холбогдож байна.ЦХХХЯ-тай хамтран төрийн албан хаагч болон төрийн үйлчилгээний оператор ажилтныг сургах сургалтыг 2023 онд 2 удаа зохион байгуулж, 1100 гаруй иргэд, төрийн албан хаагчид хамрагдаж, цахим үйлчилгээний талаарх мэдлэг чадвараа дээшлүүлсэн. Аймгийн Төрийн цахим үйлчилгээний хэлтсээс иргэдэд И-Бизнес дээр шинээр нэвтэрч буй үйлчилгээний сургалт, Цахим хөгжлийг дэмжих хуулиудын танилцуулга сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулж байна. Мөн Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх, Тоон гарын үсгийг иргэдэд олгох ажлыг эрчимжүүлэх зорилгоор УБХ-ээс төрийн байгууллагын албан хаагчдыг тоон гарын үсэгт хамруулах төлөвлөгөө гарган ажиллаж байна.	70
5.1.3	Төрийн үйлчилгээний чанарын стандартыг бий болгож, төрийн үйлчилгээнд иргэд, олон нийт хяналт тавих нөхцөл бүрдэн, иргэдийн итгэлийг хүлээсэн үйлчилгээний соёл төлөвшүүлнэ	Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн хувь	Жилд нэг удаа	60.5%	61.5%	Төрийн үйлчилгээний чанарын стандартыг нэвтрүүлэх бэлтгэл ажил хангагдаж, төрийн үйлчилгээнд иргэд, олон нийт хяналт тавих нөхцөл бүрдэн, иргэдийн итгэлийг хүлээсэн үйлчилгээний соёл, цахим шилжилтийг эрчимжүүлэн ажиллаж байна.	50
5.1 ДҮГЭЭР ЗОРИЛТЫН ДҮН							63.33
5.2	УХААЛАГ БҮТЭЦ						
5.2.1	Иргэдээ сонсдог, иргэдийн санал бодолд тулгуурлан шийдвэр гаргадаг тогтолцоог бий болгоно	Оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ	Жилд нэг удаа	80.0	105.0	Иргэдээ сонсдог, иргэдийн санал бодолд тулгуурлан шийдвэр гаргадаг тогтолцоог бий болгох зорилгоор аймгийн Засаг дарга, хэлтэс агентлагийн удирдлага, холбогдох албан хаагчдын хамт сумдад ажиллаж, ард иргэдийн зүгээс гарсан хүсэлт, санал бодлыг сонсож, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө баталж, бодлого, хөтөлбөртөө тусган ажиллаж байна. Аймгийн Засаг даргын Тамгын газарт 7046-1212 утсаар болон zavkhan.gov.mn вэб сайтаар дамжуулан иргэдийн санал, хүсэлтийг тогтмол хүлээн авч шийдвэрлэж байна.Төрийн үйлчилгээг цахимаар иргэдэд хүргэх зорилтын хүрээнд орон нутгийн иргэдэд төрийн үйлчилгээг цахимаар хэрхэн авах талаар заавар, зөвлөмж өгч гарын авлагаар ханган ажиллаж байгаагийн зэрэгцээ төрийн үйлчилгээний талаар иргэдийн санал, хүсэлтийг цахимаар авч, холбогдох төрийн байгууллага, албан тушаалтанд шилжүүлэн үүрэг чиглэл өгч, хуулийн хугацаанд хариуг хүргүүлэн ажиллалаа. Төрийн үйлчилгээг цахимаар авах сургалт зөвлөгөөг орон нутгийн иргэд тогтмол хүргэж байгаагийн зэрэгцээ аймгийн 100 жилийн ойгоор иргэдийн санал хүсэлтийг хүлээж авах, иргэд, байгууллагыг холбох зорилго бүхий call center байгуулан Цахилгаан холбоо ХХК-тай хамтран үр дүнтэй ажилласан. Түүнчлэн 2023 онд төрийн цахим үйлчилгээний хэлтэстэй хамтран иргэдэд И-Бизнес дээр шинээр нэвтэрч буй үйлчилгээний сургалт, Цахим хөгжлийг дэмжих хуулиудын танилцуулга сургалтыг аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд сурталчилж, давхардсан тоогоор 15000 гаруй иргэнд төрийн цахим үйлчилгээг үзүүлсэн байна. 2023 онд нутгийн захиргааны байгууллагууд нийт 1113 иргэдийн өргөдлийг хүлээн авснаас 1028 хүсэлт, 41 гомдол, 44 саналыг хүлээн авч хуулийн хугацаанд хариу өгч шийдвэрлэн нийт 40,0 сая төгрөгийн тусламжийг үзүүлсэн.	70
5.2.2	Төр, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ	Хамтран ажиллахаар байгуулсан гэрээний тоо	Жилд нэг удаа	10	65	Төрийн зарим үйлчилгээг гэрээлэн гүйцэтгүүлэхээр 6 төрийн бус байгууллагатай гэрээ байгуулан 117.2 сая төгрөгийг Нийгмийн халамжийн сангаас зарцуулсан. Үүнд "Завхан аймгийн Ахмадын хороо, "Хөтөч анд" бие даан амьдрах төв, зэрэг төрийн бус байгууллагууд өдрийн үйлчилгээг явуулж 110 иргэнд 5.3 сая төгрөг, Улаан загалмайн нийгэмлэг нь сургалт явуулж 50 иргэнд 2.0 сая төгрөг, Протез ортопед тусгай хэрэгсэл бэлтгэн нийлүүлдэг 11 байгууллага 7 сумын 774 иргэнд үйлчилгээ үзүүлж 109.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Мөн гэр бүлийн хүчирхийллийн хохилогчийг хамгаалах Нэг цэгийн үйлчилгээний төв, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй Халуун сэтгэл эцэг эхийн холоо, Амар амьдрал ТББ, Цогт фитнес, АМКА dance байгууллагуудад орон нутгийн төсвөөс 45,5 сая төгрөгийн санхүүжилт олгож, төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлсэн.	70

5.2 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН							70.0
ЧАДВАРЛАГ ТӨРИЙН АЛБА							
5.3							
5.3.1	Төрийн албаны мэргэшсэн тогтвортой байдлыг хангаж, нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ	Нийгмийн асуудлыг хангахад зарцуулсан хөрөнгө оруулалтын дүн	Жилд нэг удаа	15.0	40.0	Төрийн албаны тухай хуулийн дагуу Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, чадавхжуулах, ёс зүй, сахилга хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлэх зорилт дэвшүүлэн, аймгийн Засаг даргын захирамжаар 2022 оныг "Завхан аймгийн төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх жил" болгон зарлаж, төлөвлөгөө гарган хэрэгжүүлсэн.Зарласан жилийн хүрээнд "Төрийн албан хаагчийн сахилга хариуцлагыг өндөржүүлж, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх чиглэлээр шинэлэг ажил зохион байгуулж, санал санаачилга гаргасан" байгууллагуудыг шалгаруулахаар 1 сарын хугацаатай аян зарлаж шилдэг байгууллага, ёс зүйн зөвлөлийг шагнаж урамшуулсан.Төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд төрийн байгууллагуудын дарга, эрхлэгч, төсвийн шууд захирагч нарт төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг сайжруулах талаар хөдөлмөрийн дотоод журманд тусгаж, хөтөлбөр төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх үүрэг чиглэлийг өгч, хяналт тавин ажиллаж байна. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан "Аз жаргалтай ажлын байр" арга хэмжээний хүрээнд 2022 онд төрийн байгууллагуудын дунд аян зарлаж, үр дүнг нэгтгэн дүгнэсэн.Төрийн албан хаагчдыг сургаж дадлаажуулах, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийн дагуу 2023 оны төлөвлөгөөг боловсруулж, батлуулж хэрэгжүүлж ажиллалаа. Удирдлагын академийн сургалтын төлөвлөгөөний дагуу улсын төсвийн санхүүжилтээр болон байгууллагын зардлаар эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 4, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 22, дунд хугацааны давтан сургалтад 16, төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх анхан шатны сургалтад 6, богино хугацааны сургалтад 118 албан хаагч хамрагдаж байна. Нутгийн захиргааны байгууллагуудаас ирүүлсэн санал, хүсэлтийг үндэслэн аймгийн Засаг даргын захирамжаар төрийн захиргааны зэрэг дэв авах болзол шаардлагыг хангасан 212 албан хаагчдад зэрэг дэв шинээр болон ахиулан олгосон.	70
5.3.2	Төрийн албан хаагчийн хүний нөөцийг бэлтгэж, чадавхжуулна	Сургалтанд хамрагдсан ТАХ-ийн тоо	Жилд нэг удаа	5,299	10,500	Төрийн албаны тухай хууль тогтоомж, Монгол Улсын Засгийн газар болон аймаг, орон нутгаас дэвшүүлсэн бодлого, зорилтын хүрээнд төрийн албан хаагчдыг сургаж дадлаажуулах, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийн дагуу жил бүр төлөвлөгөө батлуулан ажиллаж байна. 2022 онд Удирдлагын академийн сургалтын төлөвлөгөөний дагуу улсын төсвийн санхүүжилтээр болон байгууллагын зардлаар эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 10, дунд хугацааны давтан сургалтад 20, төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх анхан шатны сургалтад 18, богино хугацааны сургалтад 42, нийт 91 албан хаагч цахим хэлбэрээр хамрагдаж мэдлэг боловсролоо дээшлүүлсэн бол 2023 онд эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 4, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 22, дунд хугацааны давтан сургалтад 16, төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх анхан шатны сургалтад 6, богино хугацааны сургалтад 118 албан хаагч хамрагдаж байна. Түүнчлэн Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулж буй 7 хоног бүрийн "Гүрээ" гарагийн сургалтад хэлтэс, агентлагийн дарга нар болон аймаг, сумдын ЗДТГ-ын дарга мэргэжилтнүүдийг хамруулан энэ ажил тогтмолжсон. Тайлант онд нийт давхардсан тоогоор 5000 гаруй төрийн албан хаагч танхимын болон цахим сургалтад хамрагдсан байна.	70
5.3.3	Авлигаас ангид аймаг байна	Авлигын индекс	Жилд нэг удаа	81.1%	92.0%	Энэ онд НҮБ-аас Авлигын эсрэг конвенц батлагдсаны 20 жилийн ойг тохиолдуулан "Дэлхий нийтээрээ авлигын эсрэг нэгдье" уриалгыг дэвшүүлэн, тус конвенцод нэгдсэн улс орон бүр зорилтот үйл ажиллагаа хэрэгжүүлж байна. Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг "Авлигатай тэмцэх жил" болгон зарласны дагуу олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх чиг үүргийнхээ хүрээнд авлигын эсрэг нэгдэе үндэсний хэмжээний нөлөөллийн аяныг эхлүүлж, Завхан аймаг уг аянд нэгдэн Улиастай сумын орох гарах самбар, мөн Улиастай сумын "Чигэстэй голын гүүр"-ний хэсэгт "Нэгдэе" аяны сурталчилгааны самбарыг байрлуулсан. 2023 оны авлигын эсрэг төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулан ажиллаж байна. "Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг хууль тогтоомж" сэдэвт сургалтыг сумын Засаг дарга, Тамгын газрын дарга нар, төрийн захиргааны албан хаагчдад зохион байгуулж, нийт 500 гаруй албан хаагч хамрагдлаа. Аймгийн ЗДТГ шударга байдлын үнэлгээгээр аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газруудаас 79.5 оноогоор 2 дугаар байрт шалгарсан байна.	70
5.3 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН							70.00
ТАВДУГААР БҮЛГИЙН ДҮН							67.78
ЗУРГАА: НОГООН ХӨГЖИЛ							
ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТАГ							
6.1							
6.1.1	Онцлог экосистем бүхий газар нутгийг тусгай хамгаалалтанд авна	Нийт тусгай хамгаалалттай газар нутаг	5 жилд нэг удаа	42.5%	46.5%	2023 оны байдлаар Яруу суманд 3252,83 га талбай отрын бүс, 55679.09 га талбайг байгалийн нөөц газар орон нутгийн хамгаалалтанд, Улсын тусгай хамгаалалтанд 18.6 га буюу 1.5 сая га талбайг авсан. Дугант, Их мянган, Ойгон нуурыг орон нутгийн тусгай хамгаалалтанд авахаар аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулсан.	50
6.1 ДҮГЭЭР ЗОРИЛТЫН ДҮН							50
БАЙГАЛИЙН НӨӨЦ БАЯЛАГ							
6.2							

6.2.1	Амьтны нөөцийг хамгаална	Хэрэгжүүлсэн хамгааллын арга хэмжээ	Жилд нэг удаа	7	16	ENSURE төсөл нь 2020-2022 онд 77 тарвага нутагшуулсан. 2023 онд Тосонцэнгэл суманд 21 толгой, Их-Уул суманд 20 толгой нийт 41 толгой тарвага нутагшууллаа. Алдархаан, Цагаанчулуут, Цэцэн Уул, Идэр, Түдэвтэй, Цагаанхайрхан, Сонгино, Шилүүстэй сумдад 19 цэгт 767 боодол өвс 89 уут хужир, 30 уут тэжээл байршуулж биотехникийн арга хэмжээ авч, 30 уут хужир нөөцлөөд байна. Амьтны нөөцийн судалгааг хийхээр Алдархаан, Шилүүстэй, Яруу сумдын БНАТ-ийн орлогоос 47.0 сая төгрөг төвлөрүүлэн тендер зарлан Отгон бор хавцал ТББ шалгарсан. Судалгааны ажлыг 7 дугаар сараас эхэлсэн.	70
6.2.2	Нэн ховор, ховор ургамлын генетикийн нөөцийг хамгаалж, ашиглалтын нөөц бий болгоно	Хамгаалагдсан зүйл	Жилд нэг удаа	26	26	ENSURE төслийн санхүүжилтээр нэн ховор болон ховор ашигт ургамлыг тарималжуулах бичил төсөл зарлан Тосон ногоон хөгжил ТББ шалгарсан бөгөөд ургамал тариалах бэлтгэл ажил хийгдэж байна. Эрдэнэхайрхан суманд "Мон хими ХХК" хамтран 10 га газарт Монгол хунчрыг хашиж хамгаалах ажлыг эхлүүлсэн. Цаашил санхүүжилтийг шийдвэрлэсэнээр говийн нэн ховор, ховор ургамлыг үрээр тарималжуулах нөхцөл боломж бүрдэх юм.	30
6.2.3	Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ	Ойгоор бүрхэгдсэн талбай	Жилд нэг удаа	6%	6.10%	Түдэвтэй сумын Шар нуруу багийн Ар цагаан чулуу нэртэй газрын доройтсон ойн 20 га талбайд улсын төсвийн хөрөнгөөр Хан хөвч ХХК бортготой тарьцаар ойжуулах ажил гүйцэтгэсэн. 1 га талбайд 2500, 20 га талбайд 50000 ширхэг шинэсний тарьц тарьсан. Тосонцэнгэл суманд Хавчгийн ногоон мод ХХК, Хан хөвч ХХК, Ойн их хишиг ХХК, Шилүүстэй хангай ХХК, Ургах нахиа ХХК, Агь наран булаг ББН Их-Уул суманд Нисдэг үр ББН, Улиастай суманд Сайд-Уул БГБХН тус тус шилмүүст модны тарьц суулгац тогтмол үржүүлж байна. 2023 онд Тэлмэн суманд Даян ангирт ХХК мод үржүүлгийн газар байгуулж шилмүүст болон навчит модны тарьц суулгац үржүүлж байна.	70
6.2.4	Ойн сангийн төлөв байдлыг сайжруулна	Шатсан ойн талбайн хэмжээ	Жилд нэг удаа	133	124	Улсын төсвийн санхүүжилтээр Баянтэс сумын ойн сангийн 30 га талбайд Грийн пантом ХХК, Нөмрөг сумын ойн сангийн 30 га талбайд Мөнх ногоон ой ХХК, Түдэвтэй сумын ойн сангийн 40 га талбайд Хавчгийн ногоон мод ХХК, орон нутгийн төсвийн санхүүжилтээр Тосонцэнгэл сумын ойн сангийн 25 га талбайд тус тус байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг хийж гүйцэтгэсэн. Нийт 125 га талбайд байгалийн сэргэн ургалтад туслах ажил хийгдсэн бөгөөд хөрсийг 40смх40см хуулж талбар гарган шинэсний үр тарьсан.	70
6.2.5	Усны нөөцийн бохирдол, хомсдлоос сэргийлнэ	Хамгаалалтын бүсийн дэглэм	Хагас жилд нэг удаа	80%	95%	Алдархаан, Дөрвөлжин, Завханмандал, Цагаанчулуут, Цэцэн-Уул, Эрдэнэхайрхан сумдад Адапт төслийн хөрөнгөөр 6 булгийн эхийг хашиж хамгаалах ажлын тендерийг зарласан. Хяргас нуур Завхан голын сав газрын захиргааны ажлын хэсэгт хүлээлгэж өгсөн. Улиастай, Алдархаан, Цагаанхайрхан, Эрдэнэхархан сумдад Усан сан бүхий онцгой болон энгийн хамгаалалтын бүсийн тэмдэгчүүлэлтийн 13 ширхэг самбарыг хийж гүйцэтгэлийг хүлээлгэж өгсөн.	70
6.2.6	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн механизмыг хэрэгжүүлэх замаар нөөцийн зохистой ашиглалт, хамгааллыг сайжруулна	Хөрөнгийн зарцуулалт	Жилд нэг удаа	11%	60%	2023 оны байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын хувь хэмжээ, орлогоос зарцуулах арга хэмжээний төлөвлөлтийг www.eic.mn мэдээллийн санд 24 сумын төлөвлөлтийг 7 дугаар сарын 25-ны дотор бүрэн оруулсан. 2023 оны 11 дүгээр сарын 07-ны байдлаар агнуурын нөөцийн төлбөрөөс 336,519.00, Ойн нөөц ашигласны төлбөрөөс 6,314.00, ахуйн хэрэглээний ус ашигласан төлбөрөөс 25,601,00, Үйдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр 163,294.00 мянган төгрөгийг төвлөрүүлээд байна. Мөн давсан орлогыг 11 дүгээр сарын 25-ны дотор мэдээллийг оруулахаар төлөвлөн ажиллаж байна. "Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль", "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын хэрэгжилтийг хангах зорилгоор ENSURE төслийн санхүүжилтээр БИО-ФИН төслөөс 24 сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, хурлын нарийн бичгийн дарга, төлөөлөгчид, Засаг дарга, Төрийн сангийн мэргэжилтэн, Татварын байцаагч, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, Байгаль хамгаалагч 100 гаруй иргэдэд цахимаар сургалтыг зохион байгуулж мэргэжил арга зүйн зөвлгөө өгч ажилласан.	70
6.2 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН							63.33
6.3	ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИН						
6.3.1	Эвдэрсэн доройтсон газар нутгийг сэргээнэ	Талбай	Жилд нэг удаа	15.64	31.31	Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 4 аж ахуй нэгж техникийн нөхөн сэргээлт 11,43 га-д 29,230,000, биологийн нөхөн сэргээлт 3,1 га-д 24,930,0 төгрөг зарцуулсан	70

6.3.2	Байгаль эзлтэй технологи нэвтрүүлэх замаар орчны бохирдлыг бууруулна	Орчны бохирдол	Жилд нэг удаа	30%	10%	2022 онд Яруу, Их-Уул сумдын төвлөрсөн цэвэр, дулааны шугам сүлжээ, халаалтын зуухны ажлыг хийж ашиглалтад орсон. Тус 2 сум холбогдсоноор Завхан аймгийн 24 сумаас 23 сум төвлөрсөн цэвэр, дулааны шугам сүлжээнд холбогдож, олон жижиг халаалтын зуух, төвлөрсөн нэг болж, хөрсний болон орчны бохирдол буурсан. Мөн Шинэ сум төслийн хүрээнд Алдархаан, Отгон сумдад хоногт 50м3 бохир ус цэвэрлэх байгууламж баригдаж ашиглалтад орсон. 2023 онд Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй Улиастай хотод 25 мВТ-ын дулааны станц БНСолонгос улсын хөнгөлөлттэй зээлээр баригдаж эхэлсэн. Тус станцын ажил 30%-ийн гүйцэтгэлтэй ажил хийгдэж байна. Тус станц нь хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт технологитой бүрэн автоматжуулсан дулааны станц юм. Мөн Улиастай хотод Польш улсын хөнгөлөлттэй зээлээр хоногт 3000 м3 бохир ус цэвэрлэх байгууламжийн угсралтын ажил эхэлсэн хийгдэж байна. Тус цэвэрлэх байгууламж нь бохир усыг 90% хүртэл цэвэрлэдэг саарал усыг дахин ашиглах, лагаар хөрсний бордоо хийдэг хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт технологиор баригдаж байгаа цэвэрлэх байгууламж юм. Сумын сургууль цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг бага оврын ариун цэврийн байгууламжаар солих ажлын хүрээнд Тэс, Баянтэс, Асгат сумдын бага оврын цэвэрлэх байгууламжийн ажлыг Жавхланттур ХХК, Отгон, Яруу, Ургамал, Баянхайрхан сумын ажлыг Сити медиа ХХК, Сантмаргаз, Нөмрөг, Сонгино сумын ажлыг Сантех-Увс ХХК, Цагаанхайрхан, Дөрвөлжин Түдэвтэй Алтан түнгэл ХХК тус тус шалгаран зураг төслийн ажил хийгдэж, 13 сумын нүхэн жорлонг бага оврын ариун цэврийн байгууламжаар солих ажил иж бүрэн хийгдсэн. НҮБ-ын төслийн хөрөнгө оруулалтаар Завхан аймгийн Нөмрөг, Ургамал сумын ЭМТ-ийн барилгын нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих ажил хийгдэж ашиглалтад орсон.	30
6.3.3	Уул уурхайн ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлнэ	Зөрчил	Жилд нэг удаа	44	0	Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 4 аж ахуй нэгж техникийн нөхөн сэргээлт 11,43 га-д 29,230,000, биологийн нөхөн сэргээлт 3,1 га-д 24,930,0 төгрөг зарцуулсан. 2 удаагийн хяналт шалгалтаар 38 зөрчил илрүүлж улсын хяналтын байцаагчийн хугацаатай албан шаардлагыг хүргүүлж зөрчлийг арилгуулсан.	70
6.3 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН							56.67
6.4	УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ						
6.4.1	Ус, цаг уурын ажиглалтын болон орчны хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлнэ	Эзлэх хувь	Жилд 6 удаа	29%	95%	Аймгийн хэмжээнд цаг агаарын хуурайшилтыг бууруулах зорилгоор цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх ажлыг 4 дүгээр сарын 10-аас эхлэн нийт 10 удаа, газрын генератор 3 удаа нийт 13 удаагийн үйл ажиллагаа явуулсан. Цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээллэх, сэрэмжлүүлэх зорилгоор нийт 105 удаа АНХААРУУЛГА, 8 удаа СЭРЭМЖЛҮҮЛЭГ, 5 удаа УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ мэдээ зохиож, олон нийтийн сүлжээ болон багц мессежээр ард иргэдэд шуурхай хүргэж ажилласан. Багц мессежээр нийт 19 удаа (шар ус, хүйтэн бороо, их бороо, цочир хүйтрэлт, цасан болон шороон шуурга, хүчтэй салхи зэргээр) 192000 хүнд хүргэж үйлчилсэн байна. Цаг агаарын мэдээний илрүүлэлт 100%, таарч 90.8%, онч 92.5% байна. Цаг уур, орчны шинжилгээний газарт БНХАУ-лсаас Автомат хэмжигч багаж тоног төхөөрөмжийн нийлүүлэлт хийгдсэн	70
6.4.2	Байгаль орчны салбарын хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ	Арга хэмжээ	Жилд нэг удаа	10	40	Ойн ангиуд харьяа ойн мэргэжлийн 54 байгууллагатай Тэр бум мод тарих үндэсний хөдөлгөөний хүрээнд хариуцлагын гэрээ байгуулан ажиллаж байна. Мөн мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 16 ААНБ, нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжин 24 сумд 100.0 сая төгрөгийн өртөг бүхий усалгааны систем бүхий иж бүрэн хүлэмж хүлээлгэн өгсөн. Ensure төсөлтэй хамтран 10 арга хэмжээ, АДАПТ төсөлтэй хамтран татмын ойжуулалт, цэвэрлэгээ, ойн нөхөн сэргээлтийн арга хэмжээг хэрэгжүүлж байна.	70
6.4 ДҮГЭЭР ЗОРИЛТЫН ДҮН							70
ЗУРГААДУГААР БҮЛГИЙН ДҮН							60.00
ДОЛОО. АМАР ТАЙВАН АМЬДРАЛ							
7.1	БАТЛАН ХАМГААЛАХ						

7.1.1	Өсвөр үе, залуучуудад цэрэг эх оронч хүмүүжил олгоно	Хамрагдсан хүний тоо	Жилд нэг удаа	1,500	2,000	Аймгийн 2021, 2022, 2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллахад 30.0 сая төгрөг тусган батлуулсан. Хүүхэд, залууст цэрэг, эх орон үзэл хүмүүжлийг төлөвшүүлэх, сурталчлах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байна. Давхардсан тоогоор 10 арга хэмжээнд 3000 гаруй хүүхдэд хамрагдаад байна. Тухайлбал ЗХЖШ-аас зохион байгуулсан “Зэвсэгт хүчин 100” сэдэвт гар зургийн уралдаан, Монгол цэргийн нэгдсэн холбооноос зохион байгуулсан “Эрхмийн дээд Монгол эр хүн” сэдэвт эссэ бичлэгийн уралдааныг орон нутагт зохион байгуулан шалгарсан бүтээлүүдийг 2-р шатанд хүргүүлсэн. Улсын уралдаанд оролцсон бүтээлүүдээс 1 бүтээл 3-р байр, 3 бүтээл тусгай байрт шалгарсан. Монгол хүн сансарт ниссэний 40 жилийн ойг тохиолдуулан тухай өдөр төрсөн 3 иргэнд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулав. Монгол цэрэг Нэгдсэн үндэсний байгууллагын энхийг сахиулах ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойн баярыг тохиолдуулан аймагт үйл ажиллагаагаа явуулж буй Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудыг хамруулсан “Монгол цэрэг энхийн үйлсэд” нээлттэй хаалганы өдөр, сурталчилгааны арга хэмжээг 2022 оны 05 дугаар сарын 29-ний өдөр аймгийн төв талбайд зохион байгуулж, 250 гаруй хүүхэд, залуучууд хамрагдсан. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Бидний бахархал” төслийн хүрээнд “Монгол хурандаа нийгэмлэг”-ээс 21 аймаг, 9 дүүрэгт явагдаж байгаа энэхүү арга хэмжээг Завхан аймагт зохион байгуулахаар “Монгол хурандаа” нийгэмлэгийн удирдах зөвлөлийн гишүүн, Зэвсэгт хүчний бэлтгэл хурандаа Ц.Баярсайханаар ахлуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн ирж ажиллалаа. Сурталчилгааны арга хэмжээ аймгийн Тосонцэнгэл, Сонгино, Улиастай сумдад явагдаж, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын офицер, ахлагч нар, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид нийт 800 гаруй хүүхэд залуус, иргэд хамрагдлаа.	70
7.1.2	Орон нутгийн хамгаалалтын бэлэн байдлыг бэхжүүлнэ	Хэрэгжилтийн хувь	Жилд нэг удаа	20%	100%	Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2019 онд аймгийн Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг батлуулав. 2020 онд сумын Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг батлав. 2021 онд Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний дагуу томилгоот нэгжийн бүрэлдэхүүнийг оногдуулан данслав. 2022 онд Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бүрэлдэхүүний удирдах бүрэлдэхүүний сургалтыг зохион байгуулав. 2023 онд Орон нутгийн хамгаалалтын томилгоот бүрэлдэхүүний сургалт дадлагыг анх удаа Тэлмэн суманд зохион байгуулав. Орон нутгийн хамгаалалтын санхүүгийн нөөц бүрдүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулж байна.	90
7.1.3	Дайчилгааны төлөвлөлтийг зохион байгуулна	Хэрэгжилтийн хувь	Жилд нэг удаа	50%	80%	Аймгийн “Зэвсэгт хүчний нэгтгэл ангийг дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах төлөвлөгөө”, “Байлдааны бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх төлөвлөгөө”, Орон нутгийн цэргийг байгуулах төлөвлөгөө”-г шинэчлэн боловсруулж 2021 оны 05 дугаар сарын 21 өдөр Зэвсэгт хүчний Жанжин штабын даргаар батлуулсан. Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2021 оны мн/115 дугаар тушаалаар зохион байгуулагдсан “Оператив-тактик хээрийн сургууль”-д 2021 оны 08 дугаар сарын 09-19-ний өдрүүдэд аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб, Сонгино сумын батлан хамгаалах товчоо, дайчилгааны даалгавраар оногдуулан бүртгэгдсэн цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнүүдийг оролцуулсан. 2022 онд сумын “Зэвсэгт хүчний нэгтгэл ангийг дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах төлөвлөгөө”, Орон нутгийн цэргийг байгуулах төлөвлөгөө”-г боловсруулан батлуулсан. Дайчилгааны болон Орон нутгийн цэргийн төлөвлөгөөнд жил тодотгол хийж байна.	90
7.1 ДҮГЭЭР ЗОРИЛТЫН ДҮН							83.3333333
7.2.	НИЙГМИЙН АМАР ТАЙВАН БАЙДАЛ						
7.2.1	Гэмт хэргийн гаралтыг бууруулан, илрүүлэлтийг нэмэгдүүлнэ	Гэмт хэргийн илрүүлэлт /хувиар/	Сар бүр	67.1%	70.0%	Аймгийн хэмжээнд 2023 онд хулгайлах төрлийн 84 гэмт хэрэг бүртгэгдэн шалгагдсанаас 52 гэмт хэргийг илрүүлэн илрүүлэлт 61.9 хувьтай тооцогдож байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. 2023 онд кибер орчинд үйлдэгдэж байгаа залилах гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 25 нэгжээр буурсан үзүүлэлттэй байна. Мөн бүртгэгдэн шалгагдаж байгаа 38 гэмт хэргээс 22 гэмт хэргийг илрүүлж илрүүлэлт 57.7 хувьтай байна. Цахим орчинд мөрийтэй тоглоом зохион байгуулсан 10 гэмт хэрэг бүртгэгдэж 5 гэмт хэргийг илрүүлэн илрүүлэлт 50 хувьтай тооцогдож байна. Аймгийн хэмжээнд 248 гэмт хэрэг бүртгэгдэн шалгагдсанаас 162 гэмт хэргийг илрүүлэн эрүүгийн хэрэг үүсгэж шүүхээр шийдвэрлүүлэн гэмт хэргийн илрүүлэлт 65.3 хувьтай тооцогдож байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	70

7.2.2	Зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангана	Зам тээврийн гэмт хэрэг буурсан үзүүлэлт /нэгж/	Жилд хоёр удаа	25	12	Хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд улсын чанартай А0603,А1102,А18 дугаартай авто замуудад зам тээврийн осол учирч болох эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн ГХУСАЗСЗ мөн авто жолооны курсуудын холбоотой хамтран улсын хэмжээнд "Нэг зам-Нэг соёл" арга хэмжээний үед давхардсан тоогоор 2560 алба хаагч ажиллаж аялал жуулчлалын бүс нутгийг зорих хөдөлгөөн нэмэгдсэнтэй холбогдуулан 3950 жолоочид зөвлөгөө зөвлөмж өгч тээврийн цагдаагийн албанаас зохион явуулсан 15 нэгдсэн болон тусгай арга хэмжээг зохион явуулж бага насны хүүхдүүдийн замын хөдөлгөөний дүрмийн мэдлэгийг олгох зорилгоор " Ногоон гэрэл, цагаан шугам," Замын хөдөлгөөний цагаан толгой" тэмцээнүүдийг тус тус амжилттай зохион байгуулж зам тээврийн ослыг бууруулах чиглэлээр тодорхой төрлийн арга хэмжээнүүдийг зохион байгуулан замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн 24.739 жолоочид 585.292.400 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 751 зөрчил илрүүлж 467 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилийн хугацаагаар хасч 173.200.000 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжаа авч 284 иргэнийг сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 7-30 хоногийн хугацаагаар баривчлуулсан байна.	70
7.2.3	Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлнэ.	Эрх зүйн сургалт, сурталчилгаа хүргэсэн иргэдийн тоо	Жилд хоёр удаа	9000	10000	Хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн эрх зүйн хөтөч буланг Цахим хөгжлийн хэлтсийн байранд шилжүүлэн байрлуулж иргэдийн хууль зүйн мэдээлэл авах нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байна. Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран 2020 оны 12 дугаар сард аймгийн хэмжээнд 53 эрх зүйн хөтчийг бэлтгэсэн бөгөөд уг хөтөч нартай жил бүр хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж, гэрээний хэрэгжилтийг 12 дугаар сард дүгнэн ажиллана.	70
7.2.4	Орон нутгийн гамшгаас урьдчилан сэргийлэх чадавхыг дээшлүүлнэ	Бэлтгэл сургалтанд хамрагдсан иргэд, ААН-ийн хувь	Жилд нэг удаа	18%	50%	2023 оны 11 сарын байдлаар Гамшгаас хамгаалах ангиллын сургалт, дадлагыг 223 удаа, 895 цагийн багтаамжтай 9314 иргэнийг хамруулан зохион байгуулсан. Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах журмын дагуу 2023 оны 06-р сарын 09-ний өдрийн 16 цагт дадлага сургуулийг зохион байгуулсан. Тус дадлага сургуульд аймаг сумын Онцгой комиссын 253 хүн, 31 автомашин, гамшгаас хамгаалах алба мэргэжлийн ангийн 1268 хүн, 28 автомашин, 24 сумын ерөнхий зориулалтын мэргэжлийн ангийн 1365 хүн, 123 автомашин, 142 аж ахуй нэгж байгууллагын 234 ажилтан, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 1404 сурагч, хүүхдүүд, 14550 иргэн, 130 автомашин нийт 17949 хүн 225 автомашин, техник хэрэгсэлтэй оролцсон. Монгол Улсын Шадар сайд аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний 3.12 дахь хэсэг, Онцгой комиссын 2023 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсан заалтуудыг хэрэгжүүлэх, аймаг орон нутагт тохиолдож болзошгүй гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах хор уршгийг арилгах, сэргээн босгоход сумын Онцгой комисс, ерөнхий зориулалтын мэргэжлийн анги, аж ахуй нэгж байгууллага, ард иргэдийн бэлэн байдлыг дээшлүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 31-ны өдрийн баталсан Ургамал, Түдэвтэй сумдад Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль, Шилүүстэй, Цагаанхайрхан сумдад гамшгаас хамгаалах команд штабын сургууль, Эрдэнэхайрхан, Дөрвөлжин сумдад гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг зохион байгуулах удирдамжийн дагуу 2023 оны 10 дугаар сарын 18-ний өдрөөс 10 дугаар сарын 29-ны хооронд зохион байгуулсан. Сумдын үнэлгээ: Түдэвтэй сум-91% А, Ургамал сум- 78.5% С, Цагаанхайрхан сум-90.7% А, Шилүүстэй сум-74% С, Эрдэнэхайрхан сум-85% В, Дөрвөлжин сум-70.3% С. Сургалтанд нийт 3197 хүн хамрагдсан.	70
7.2 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН							70
7.3	ХУУЛЬ САХИУЛАХ						
7.3.1	Орон нутаг дахь хууль сахиулах байгууллагуудын чадавхыг бэхжүүлнэ	Хөрөнгө оруулалтаар	Жилд нэг удаа	-	2.0	Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын чадавхыг бэхжүүлэн 2023 оны 11 сарын байдлаар 247 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ.Мөн Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын хамтын ажиллагааг хангах үүднээс удирдлагуудын уулзалтыг улиралд 1 удаа зохион байгуулж байна.	70
7.3.2	Кибер аюулгүй байдлын хяналтыг сайжруулж, гэмт халдлагаас урьдчилан сэргийлнэ	Терроризмын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлд дэмжлэг үзүүлсэн хөрөнгийн хэмжээ	Жилд нэг удаа	-	8.0	Завхан аймаг дахь Салбар зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Терроризмтой тэмцэх ажиллагааг зохицуулах зөвлөлийн даргаар батлуулан ажиллаж байна. /нууц/ Аймгийн Засаг даргын захирамжаар Кибер аюулгүй байдлын хяналтыг сайжруулж, гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 3 сая төгрөгийн дэмжлэг үзүүлээд байна.	70

7.3 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН							70
МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИ							
7.4.1	Хөдөө орон нутаг, сум багийн суурин утас, интернетийн сүлжээг өргөжүүлнэ	Дахин дамжуулах станц	Жилд нэг удаа	12	18	2023 онд Отгон сумд Мобиком-1, Юнител-1, Улиастай сумд Мобиком-1, Юнител-1, Цагаанчулуут сумд Мэдээлэл холбоо сүлжээ ХХК-ийн 1 станц, нийт 5 дахин дамжуулах станц ашиглалтад орсон	70
7.4.2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр орон нутгийн онцлог үйл явдлын сурталчлан ард иргэдэд түгээнэ	Мэдээний тоо	Жилд нэг удаа	120	150	Завхан аймагт болж буй онцлох үйл явдлын мэдээ мэдээллийг орон нутгийн болон төвийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр ард иргэдэд чанартай, шуурхай, хүртээмжтэй хүргэхийг зорин ажиллаж байна.Орон нутагт зохион байгуулж буй онцлох үйл явдлын 2021 онд 300 гаруй, 2022 онд 350 гаруй мэдээллийг бэлтгэж МҮОНРТ болон орон нутгийн телевизүүд цахим сайтуудаар нэвтрүүлж, сонин сэтгүүлдүүдэд нийтлэн улс орон даяар сурталчилж ажилласан. 2023 онд орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр 100 гаруй, Монголын Үндэсний Олон Нийтийн телевизээр 35 удаагийн мэдээлэл нэвтрүүлж, орон даяар үзэгчдэд хүргэлээ. Завхан толь сонин, Монголын үнэн сонин, Мэдээллийн эрин үе зэрэг хэвлэлүүдтэй гэрээ хийж хамтран ажиллахаас гадна орон нутгийн телевизүүд, сошиал сувгуудаар мэдээ, мэдээлэл дамжуулан сурталчилсан. Завхан аймгийн 100 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдсан арга хэмжээнүүдийг төвийн 2, орон нутгийн Air1 телевиз, сонин, сайт, сошиал орчинд шууд ба шууд бус дамжуулалт хийж ажиллав. ДДШТВ-ийн 928, 929 дүгээр сувгаар орон нутгийн мэдээ мэдээллийг 24 сум, бусад аймгуудад нэвтрүүлэх зорилгоор орон нутгийн телевизүүдтэй хамтран ажиллаж, 2023 онд Air1, Шинэ Завхан телевизийн 2 сувгаар нийт 9200 цагийн эфир нэвтрүүлж, төрийн мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэж ажиллав. Аймгийн ЗДТГ-ын пэйж хуудас, вэб сайтаар орон нутгийн мэдээ мэдээллийг сурталчлан иргэдэд тухай бүрт нь хүргэлээ. Мөн аймгийн онцлох бүтээн байгуулалт, танилцуулга, видео контентыг хийж иргэдэд хүргэсэн.	70
7.4 ДҮГЭЭР ЗОРИЛТЫН ДҮН							70
ДОЛДУГААР БҮЛГИЙН ДҮН							73.3333333
НАЙМ. БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ							
8.1 АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ							
8.1.1	Аймгийн аялал жуулчлалын гол, туслах маршрутад түшиглэн үйлчилгээ, мэдээллийн төвүүдийг байгуулахад дэмжлэг үзүүлнэ	Жуулчдын тоо	Жилд нэг удаа	23920	70000	Аймгийн 100 жилийн ойн арга хэмжээний үеэр Үйлчилгээний байгууллагын мэдээллийг иргэдэд түгээх "Call center" үйлчилгээний мэдээллийг аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 82 аж ахуйн нэгжүүдийн мэдээллийг мэдээллийн төвүүдэд хүргүүлэн мөн аялалын маршрут, бүтээгдэхүүн үйлчилгээ, орон нутгийн онцлог, 9 гайхамшиг, түүх дурсгалын газруудаа сурталчласан нугалбарыг мэдээллийн төвүүдээр дамжуулсан иргэдэд тараах ажиллагааг зохион байгуулсан. Улаанбаатар Трвал Экспо-2023 Олон Улсын аялал жуулчлалын үзэсгэлэн-2023" үзэсгэлэн, "АЙТИЭМ" ОЛОН УЛСЫН ҮЗЭСГЭЛЭНГҮҮДЭД Завхан аймгаа төлөөлөн аяллын бүтээгдэхүүн үйлчилгээ сурталчилан аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар, Аймгийн аялал жуулчлалын холбоо, Жуулчны баазууд, Зочид буудал зэрэг үйлчилгээний байгууллагын төлөөлөл оролцлоо. Тус үзэсгэлэнгийн үеэр аялалын маршрут, бүтээгдэхүүн үйлчилгээ, орон нутгийн онцлог, 9 гайхамшиг, түүх дурсгалын газруудаа сурталчилсан эмхэтгэл, нугалбарыг бэлтгэж 1000 гаруй аялагчдад иргэдэд тараасан.	70
8.1.2	"Улаагчны хар нуур", "Отгонтэнгэр хайрхан"-ыг түшиглэн аялал жуулчлалыг хөгжүүлнэ	Жуулчдын тоо	Жилд нэг удаа	15000	60000	Завхан аймгийн Аялал жуулчлалын холбоотой гэрээ байгуулан аялал жуулчлалын гол бүс нутаг болох Отгонтэнгэр, Улаагчны хар нуур Алдархаан, Эрдэнэхайрхан, Яруу, Отгон, Шилүүстэй, Тэлмэн сумын нутагт нийт 20 ширхэг тэмдэг тэмдэгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.Аймгийн 100 жилийн хүрээнд "ЗАВХАН 100" тав боть ном хэвлүүлж хүлээлгэж өгсөн. Аялал жуулчлалын бүс болон тусгай хамгаалалттай газар нутагт нийт 15 эко жорлон шинээр байгуулсан .2023 оны 11 дүгээр сарын 09-ний байдлаар дотоодын 20000, гадаадын 12000 жуулчин зорин ирсэн байна.	70
8.1.3	Завхан аймагт аялал жуулчлалыг хөгжүүлэх иж бүрэн маркетингийн арга хэмжээг хэрэгжүүлнэ	Жуулчдын тоо	Жилд нэг удаа	23920	70000	Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг Монголд зочлох жил болгон зарласантай холбогдуулан 21 аймагт байрлуулж буй зочлох жилийн баннерыг Их-Уул сумын Цэцүүх багийн төвд байрлах мэдээллийн төвийн дэргэдэх мэдээллийн самбар, Улиастай сумын хясааны самбарт тус тус байрлууллаа.Монголд зочлох жил болгон зарласантай холбогдуулан орчны бохирдлыг бууруулах эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэх зорилгоор жуулчны баазуудын нүхэн жорлонг буулгаж MNS 5924:2015 стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болох Хилийн бүсийн аяллын маршрут байгалийн үзэсгэлэнт газрын түүх соёлын дурсгалт газруудын багтаасан аяллын маршрутын зураглал гаргаж замналыг тодорхойлох жуулчдыг мэдээллээр хангах жуулчдын бүс нутаг дахь уул овооны хог хаягдлыг тогтмол цэвэрлэх чиг үүргүүдийг аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд мэдэгдэх хуудсыг хүргүүлэн ажилласан. Амийн 9 гайхамшиг болон аялал жуулчлалын талаарх мэдээ мэдээллийг иргэдэд цаг тухай цахимаар сурталчилан бүр хүргэн ажилласан.	50
8.1 ДҮГЭЭР ЗОРИЛТЫН ДҮН							63.33
8.2 ХӨДӨӨ АЖ АХУЙ							

8.2.1	Эрүүл өндөр ашиг шимт мал сүргийг үржүүлнэ	Өндөр ашиг шимт малын тоо	Жилд нэг удаа	177.4	200	Улиастай, Тэлмэн, Нөмрөг, Түдэвтэй, Алдархаан, Тосонцэнгэл, Шилүүстэй сумдад сүү-махны чиглэлийн 625 үхрийг 26 иргэн, аж ахуй нэгж үржүүлж байна. Улиастай, Цэцэн-уул, Тэс, Сонгино сумдад 11 иргэн 113 тооны гахай, Улиастай, Түдэвтэй, Тэлмэн, Цагаанчулуут сумдад 5 иргэн, аж ахуйн нэгжид 3800 гаруй тооны тахиа үржүүлж байгаа нь өмнөх оны мөн үеэс эрлийз, хосолмол үхрийн тоо толгой 8%-р буурч, гахайн тоо толгой 10%-р өсч, тахиан тоо толгой 2%-иар өссөн байна. Алдархаан, Яруу, Эрдэнэхайрхан сумдад Сартуул үүлдрийн хонь, Дөрвөлжин сумд Завхан буурал үүлдрийн ямаа, Тэс, Баянтэс сумд Тэс үүлдрийн адуу, Их-Уул, Тосонцэнгэл сумд Нутгийн сарлаг зэргийг үржүүлж байна. Яруу сумын Жаргалант мал хоршооны Завхан буурал үүлдрийн 2 ухныг үрийг нь авч генийн банкинд хадгалах зориулалтаар Малын удмын сангийн үндэсний төвд хүргүүлсэн.	70
8.2.2	Бэлчээрийн даацыг нэмэгдүүлж, малын тэжээл тариалалтыг дэмжинэ	Хураан авсан ургацын хэмжээ	Жилд хоёр удаа	3	23	2022 онд 3603 га-д малын тэжээл тариалж 4768.1 тн ногоон тэжээл хураан авсан бол 2023 онд малын тэжээл 6517.1 га-д тариалалт хийж 14927.1 тн ногоон тэжээл хураан авсан нь өмнөх оноос тариалсан талбай 2914.1 га-гаар, хураан авсан ургац 10159 тн-оор нэмэгдсэн байна.	70
8.2.3	Мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний борлуулалтын сүлжээг бий болгоно	Байгуулсан сүлжээний тоо	Жилд нэг удаа	0	2	Завхан аймгийн хэмжээнд мах боловсруулах чиглэлээр "Завхан хүнс" групп, "Завхан Мах маркет" ХХК, "Тэс –Шим" хоршоо, "ЭДГС" ХХК үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Улаанбаатар хот дахь мах боловсруулах гэрээт үйлдвэрүүдэд мал мах бэлтгэн нийлүүлж байна.	70
8.2.4	Малчдын нийгмийн асуудлуудыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ	Хамрагдсан малчдын тоо	Жилд нэг удаа	300	1500	2021 оны ноосны урамшуулалд хамрагдах 6824 өрхийн падааны шивэлтийг 24 сумаас авч нэгтгэн Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлсэн. Падааны шивэлтийг үйлдвэрийн шивэлттэй тулгахад анхан шатны мэдээлэл зөрүүтэй 1465, аймгийн мэдээлэл алдаатай 97, үйлдвэрийн мэдээлэл алдаатай 50 гаруй өрхийн мэдээллийг засварлан ХХААХУЯаманд хүргүүлсэн. Төрөөс малчин болон мал бүхий иргэдэд олгодог ноосны урамшуулалд 2021 онд 6843 өрхийн урамшууллын гүйлгээ хийгдсэнээс нэр, данс зөрүүтэй 4000 гаруй иргэний мэдээллийг засварлан хүргүүлсэнээс дахин засварлах шаардлагатай 152 иргэний мэдээллийг засварлан хүргүүлээд байна.Энэ онд Тосонцэнгэл сумын Рашаант, Оргих, Улаан толгой багуудад 4 малчин, Тэлмэн сумд 5 малчин, Их-Уул сумд 2 малчин, Нөмрөг суманд 5 малчин буюу нийт 17 малчин өвөлжөөндөө байшин барьсан байна. 2022-2023 оны өвөл, хаврын улиралд зэргэлдээх аймгууд руу отор нүүдэл хийх малчдын хүсэлтийг үндэслэн аймгийн Засаг даргын албан тоотыг Архангай, Хөвсгөл, Баянхонгор аймаг руу хүргүүлсэн.	70
8.2.5	Хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг аймгийн үйлдвэрлэл, үйлчилгээгээр хангахад дэмжлэг үзүүлнэ	Хэмжээ	Жилд нэг удаа	6,274.8	10,105.4	2023 оны байдлаар аймгийн хэмжээнд 602 өрх, 96 аж ахуйн нэгж үр тариа 2785 га, малын тэжээл 6517.1 га, төмс 186.6 га, хүнсний ногоо 182.7 га-д тус тус тариалалт хийж үр тариа 720.5 тн, малын тэжээл 14927.1 тн, төмс 1552.1 тн, хүнсний ногоо 1323.6 тн-ыг хураан аваад байна. Аймгийн хүн амын хэрэгцээт төмс, хүнсний ногооны 37.2 хувийг орон нутгийн үйлдвэрлэлээр хангаж байна. Улаан хальст саримсыг 16.7 га-д тариалж 38.2 тн ургац хураан авсан. Сүүний чиглэлийн эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч 11 сумын 37 иргэн аж ахуйн нэгж жилд дунджаар 310.8 тн сүү бэлтгэн зах зээлд нийлүүлж нийт хүн амын сүүний хэрэгцээний 3.2%-ийг, хөдөө аж ахуйгаас 62.8 хувийг бэлтгэж өрхийн үйлдвэрлэлийн түвшинд бэлтгэгдсэн сүү цагаан идээгээр хангаж байна.	70
8.2.6	Төв суурин газрын хүн амыг түшиглэн хүлэмжийн аж ахуйг хөгжүүлнэ	Байгуулагдсан хүлэмжийн тоо	Жилд хоёр удаа	11	65	Улиастай суманд "Загасан нүд-Загастай" ХХК 600 м2 талбайд, Тосонцэнгэл суманд "Тосон Эко хүнс" ногоочдын бүлэг 280 м2 талбайд өвлийн хүлэмжийн аж ахуйн тариалан эрхэлж байна. Аймгийн хэмжээнд 880 м2 талбайд 2 аж ахуйн нэгж өвлийн хүлэмжийн тариалан, 56 өрх зуны хүлэмжийн тариаланг 3916 м2 талбайд эрхэлж 32.7 тн эрт ургацын ногоог хүнсний хэрэгцээнд нийлүүлсэн. Энэ онд шинээр 120 м2 зуны хүлэмж байгуулагдсан.	70
8.2.7	Тариаланчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэн, залуу тариаланч бэлтгэхэд дэмжлэг үзүүлнэ	Тариаланчдын тоо	Жилд нэг удаа	250	1500	Монгол улсын Засгийн газраас газар тариалан, хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор 3 жилийн хугацаатай жилийн 3 хувийн хүүтэй хөрөнгө оруулалт, эргэлтийн хөрөнгийн хөнгөлөлттэй зээл олгох ажлын хүрээнд ХААН банк 29 иргэн, аж ахуйн нэгжид 1.5 тэр бум төгрөгийн зээлийг олгосон байна. Өрхийн тариалан эрхлэгчдийг дэмжих зорилгоор ХХААХУ-н яамнаас 49.664.628 төгрөгийн 13 төрлийн хүнсний ногооны үрийг татан авч 18 сумын тариалан эрхлэгчдэд 80 хувийн хөнгөлөлттэй үнээр Хөдөө аж ахуйн тасгаар дамжуулан олгосон.	70
8.2 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН							70.00
8.3	ДЭД БҮТЭЦ						

8.3.1	Улсын болон орон нутгийн авто замын сүлжээг өргөжүүлнэ	Хатуу хучилттай замын урт	Жилд нэг удаа	560	1200	2022 онд Загастайн давааны 67 км хатуу хучилттай авто зам, Алдархаан сум хүртэлх 6,7 км хатуу хучилттай авто зам, Улиастай сумын төв дотор Гудамж төслийн хүрээнд 6,8 км хатуу хучилттай авто зам, Алдархаан сумын төв дотор Шинэ сум төслийн хүрээнд 1,3 км хатуу хучилттай авто замыг ашиглалтад оруулсан. Идэр сумын төв хүртэлх 12 км хатуу хучилттай автозамын зураг, төсөв, Донойн нисэх буудлаас Улаагчины хар нуур хүртэлх 74 км хатуу хучилттай авто зам зураг, төсөв, Идэрийн голын 97 у/м төмөрбетон гүүр, авто замын хамт зураг, төсөв, Алтай-Улиастай чиглэлийн 198 км хатуу хучилттай авто замын зураг, төсөвүүд хийгдсэн. Алтай-Улиастай чиглэлийн 198 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийгдэхээр батлагдсан. 2024 оны төсвийн төсөлд Богд-Чигэстэй голын 290,03 у/м төмөр бетон гүүр барих, Арцсуурь боомт хүртэлх 159,5 км хатуу хучилттай авто зам барих, Идэр сумын төв хүртэлх 12 км хатуу хучилттай автозам барих зэрэг ажлуудын саналыг явуулсан. Мөн дараах сумд хүртэлх Яруу-26 км , Түдэвтэй-7 км, Сантмаргаз-50 км, Цэцэн-Уул-36 кт хатуу хучилттай авто замаар холбохоор төлөвлөж байна.	70
8.3.2	Улиастай болон зарим сумын инженерийн шугам сүлжээг шинэчилнэ	Хийгдсэн цэвэр усны шугамын уртаар хэмжинэ	Жилд нэг удаа	80	120	2022 онд Алдархаан, Отгон сумдын инженерийн шугам сүлжээ он дамнан хийгдэж байгаа бөгөөд Алдархаан сумын ажил дуусаж комисс хүлээгдэж байна. Отгон сумын дулааны шугам сүлжээ бүрэн хийгдэж дууссан. Хувийн аж ахуй нэгжийн санхүүжилтээр Их-Уул сумын төвлөрсөн халаалт, цэвэр усны шугам сүлжээ хийгдэж ашиглалтад орсон. 21-р зуун хороололд 2,4 км дулаан, хэрэглээний халуун ус, 1,2 км усан хангамж, 1,5 км ариутгах татуургын магистраль шугам сүлжээ хийгдэж ашиглалтад оруулсан. Дулааны станц, 11-н дулаан дамжуулах төв, 1-р контор буюу төв шугам сүлжээний ажлыг БНСолонгос улсын тал, 2-контор буюу дулаан дамжуулах төвөөс хэрэглэгчид хүрэх шугам сүлжээг Монгол улс хариуцан хийхээр гэрээнд тусгагдсан. Дулааны станцын 2-р хэлхээний шугам сүлжээний ажил 19,752,0 сая төгрөгийн хөрөнгийг улсын төсөвт тусгуулах санал хүргүүлсэн байна. 2024 оны Эрчим хүчний сайдын багцад Дулааны станцын ариутгах татуурга, цэвэр усны шугам, холбоо дохиоллын ажлыг суулгахаар санал хүргүүлсэн. Улиастай суманд Богдын гол баг бор дүнзэн байрны хэсэгт 400 м ариутгах татуурын шугам, Товцог багт бохир усны насос станц 2.2 км ариутгах татуургын шугамын ажил хийгдэж байна.	70
8.3.3	Төв, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулна	Сумын тоо	Жилд нэг удаа	5	10	2018-2020 онд "Шинэ сум" төслийн хүрээнд Алдархаан, Отгон сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хийлгэсэн. Мөн Улиастай хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг "Некст инженеринг" ХХК -аар хийлгэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулан хүлээн авсан. 2022 онд Цэцэн-Уул сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хийлгэсэн.	30
8.3.4	Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр баригдах барилга, байгууламж, засвар, их засварын ажлыг эрэмбэлж үе шаттайгаар шийдвэрлэнэ	Эрэмбэ	Жилд нэг удаа			Аймгийн хэмжээнд 2020-2024 оны хооронд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлыг 30 гаруй шалгуур үзүүлэлтээр эрэмбэлэн аймгийн ИТХ-ын хурлын хуралдааны 13 дугаар тогтоолоор баталгаажуулж эрэмбийн дагуу зураг төслийн ажлыг хийлгэж Улсын төсөвт батлуулах ажлыг зохион байгуулж ажиллаж байна. Дээрх эрэмбийн хүрээнд 2021 онд шинээр 11 төсөл арга хэмжээ, 2022 онд 22 төсөл арга хэмжээ шинээр батлагдсан бол 2023 онд Улсын хэмжээнд шинээр хөрөнгө оруулалтын ажил хийгдээгүй.	70
8.3 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН							60.00
НАЙМДУГААР БҮЛГИЙН ДҮН							64.44
НЭГДСЭН ДҮН							67.00

120

ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**Товчилсон үгийн тайлбар****Урт болон дунд хугацааны хөтөлбөр бодлогын баримт бичгийн товчилсон үгийн тайлбар**

МУТЖҮЧ-Монгол Улсын таван жилийн үндсэн чиглэл
ЗГҮАХ-Засгийн газрынүйл ажиллагааны хөтөлбөр
АТЖҮЧ-Аймгийн таван жилийн Үндсэн чиглэл
АЗДҮАХ-Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр

Хөрөнгийн эх үүсвэрийн товчилсон үгийн тайлбар

УТ- Улсын төсөв
ОНХС - Орон нутгийн хөгжлийн сан
ОНХС (СЗ) - Орон нутгийн хөгжлийн сан (Суурь зардал)
ОНТ - Орон нутгийн төсөв
ЖДҮХС- Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан
СХС- Сум хөгжүүлэх сан
ТХ - Төсөл хөтөлбөр
БХНСАХЗ - Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал
ЦМТ-Цэргийн мөнгөн төлбөр

БОАЖГ-Байгаль орчин аялал жуулчлалын газар
АЖХ-Аялал жуулчлалын холбоо
ГХБХБГ-Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
МХГ-Мэргэжлийн хяналтын газар
ХАҮТ-Худалдаа аж үйлдвэрийн танхим
ИНБ-Иргэний нийгмийн байгууллага
ДЗОУБ-Дэлхийн зөн олон улсын байгууллага
НДЭХ-Нийгмийн дэвшил эмэгтэйчүүдийн холбоо
УЦҮОШТ-Ус цаг уур орчны шинжилгээний төв
ТББ-Төрийн бус байгууллага
БМДИ-Багшийн мэргэжил дээшлүүлэх институт
ББОБТ-Баруун бүсийн тамирчдыг олимпд бэлтгэх төв
ХЖТ-Хөгжимт жүжгийн театр
ЗӨСТ-Зоонозын өвчин судлалын төв
АНЭ-Аймгийн Нэгдсэн эмнэлэг

БӨХ-Байгууллагын өөрийн хөрөнгө
СЗДТГ-Сумын Засаг даргын Тамгын газар /сумын өөрийн хөрөнгө/

ТНЭ-Тосонцэнгэлийн Нэгдсэн эмнэлэг
БТСГ-Биеийн тамир спортын газар
ХХҮГ-Хөдөлмөр халамж үйлчилгээний газар

Хэрэгжүүлэх байгууллага, хэлтэс, агентлагийн товчилсон үгийн тайлбар

АЗДТГ - Аймгийн Засаг даргын тамгын газар
ТЗУХ - Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
ХОХБТХ - Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс
НБХ - Нийгмийн бодлогын хэлтэс
СТСХ-Санхүү төрийн сангийн хэлтэс
ХЭЗХ - Хууль, эрх зүйн хэлтэс
ХШҮДАХ-Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэс
ЦШ-Цэргийн штаб
БГ - Боловсролын газар
ЭМГ - Эрүүл мэндийн газар
ЦГ- Цагдаагийн газар
ХХААГ-Хүнс, хөдөө аж ахуйн газар
МЭГ-Мал эмнэлгийн газар
ОНӨГ-Орон нутгийн өмчийн газар
АОК- Аймгийн онцгой комисс
ОБГ-Онцгой байдлын газар
ГБХЗХГ-Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар

СЗДТГ-Сумын Засаг даргын Тамгын газар
СГЗ-Сав газрын захиргаа
ААН-Аж ахуйн нэгж
ХТҮА-Хот тохижилт үйлчилгээний алба
ОМБ-Ойн мэргэжлийн байгууллага
СДОА-Сум дундын ойн анги
БХЯ-Батлан хамгаалах яам
СХ-Статистикийн хэлтэс
СХЗХ-Стандарт хэмжил зүйн хэлтэс
НҮБ-ХС-Нэгдсэн үндэстний байгууллагын хүүхдийн сан
ГХУССЗ-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл
УЗХ-Улаан загалмайн хороо
ЕБС-Ерөнхий боловсролын сургууль